

## Улаанбаатар Цэвэр Агаар Санаачлага II үе

Байгаль орчин, аялал жуулчлалын яам/ ЕСБХБ

Евроконсалт Мотт МакДоналд  
Ногоон Хөгжлийн Хөтөч ТББ  
Монголиан Барристерс & Солиситорс ХХК

2012 оны 3 дугаар сар





Улаанбаатар Цэвэр Агаар сан – II үе  
Гэрээний дугаар:22384/EBSF2009-09-117/01

**АГААРЫН ТУХАЙ ХОЛБОГДОХ  
ХУУЛИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Огноо: 2012 оны 3 дугаар сар

Байгаль орчин, аялал жуулчлалын яам  
ЕСБХБ

БОАЖЯ  
Засгийн газрын II байр  
Нэгдсэн үндэстний гудамж 5/2  
Улаанбаатар -210646  
Монгол улс

ЕСБХБ  
One Exchange Талбай,  
Лондон хот, EC2A 2JN,  
Их Британи

**Боловсруулсан, шинэчилсэн тэмдэглэл:**

Шинэчилсэн	Огноо	Боловсруулсан	Шалгасан	Баталсан	Тайлбар
1	17/2/12	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пийт Де Вилдт Онно Ван Ден Хийвел Сузанне Рулофс		
2	17/3/12	Б.Цэцэнбилэг Г.Сурахбаяр	Пийт Де Вилдт	Каролине Ла Чапел	Батлагдсан

## УЛААНБААТАР ХОТЫН ЦЭВЭР АГААР САНААЧЛАГА II

Улаанбаатар хотын гэр хорооллын айлууд хоол хүнс бэлтгэх, гэр сууцаа халаахдаа хэрэглэж байгаа зуух нь бүтээмж бага, мөн түлшний зориулалтаар ашиглаж буй нүүрсний чанар муу тул өвлийн улиралд агаарын бохирдлыг үүсгэдэг гол хүчин зүйл болж байна.

Улаанбаатар хотын агаарын чанарын түвшин жилээс жилд буурч, хотын хүн амын эрүүл мэнд, улс орны эдийн засагт ноцтой сөрөг нөлөө үзүүлэх хандлага нэгэнт бий болжээ.

Гэр хорооллын айлуудын ашиглаж буй зуухны загварыг сайжруулж, түүхий нүүрсийг шууд хэрэглэж байгааг шигшиж цэвэршүүлсэн, утаа ялгаруулалт багатай, үр ашигтай түлшээр солих нь Улаанбаатар хотыг хамарсан агаарын бохирдлын асуудлыг богино хугацаанд үр дүнтэй шийдвэрлэх арга зам, гарц болоод байна.

2008 оноос эхлэн Улаанбаатар хотын удирдлагууд түүхий нүүрс түлшэнд хэрэглэхийг хориглосон ч цэвэр түлшний хангамж хязгаарлагдмал, өртөг өндөр, мөн тухайн харилцааг зохицуулах хууль, эрхзүйн орчин тодорхой бус байсны улмаас тус хориг нь төдийлэн биелэлээ олоогүй юм.

Олон улсын санхүүгийн байгууллагууд (цаашид “ОУСБ-ууд” гэх), хөгжлийн агентлагууд, хандивлагч байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын (цаашид “Засгийн газар” гэх) хүсэлтээр агаарын бохирдолд нөлөөлж буй тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Дэлхийн Банк болон Азийн Хөгжлийн Банк нь зуухыг шинэчлэн солих хөтөлбөрийг боловсруулахаар тохиролцсон бөгөөд Засгийн газрын зүгээс Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкинд (цаашид “ЕСБХБ” эсвэл “Банк” гэх) түлшийг шинэчлэн солих ажлын тодорхой хэсэгт тусламж үзүүлэх хүсэлт тавьсан.

ЕСБХБ нь 2008 оны 09 дүгээр сараас түүхий нүүрсний хэрэглээг цэвэр, хор багатай түлшээр солих төлөвлөгөөг боловсруулахаар Засгийн газартай хамтран ажиллаж эхэлсэн юм. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүд 2009 оны 06 дугаар сард Засгийн газарт өргөн мэдүүлсэн Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөнд (“Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө” гэх) тусгагдсан юм. Энэхүү төслийн 1 дүгээр үе шатны үр дүнгийн нэг хэсэг нь Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө юм.

Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө нь түлшийг шинэчлэн, солихтой холбоотой, өөр хоорондоо харилцан уялдаа бүхий олон асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн цогц арга, аргачлалаас бүрдэнэ. 2010 оны 06 дугаар сард Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг Засгийн газар, Агаарын тухай багц хуулийг Монгол Улсын Парламентаар батласны дараа Банк төслийн 2 дугаар үе шатыг хэрэгжүүлэхээр зорьж байна.

Энэхүү бичиг баримт нь Засгийн газарт Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэхэд нь туслалцаа үзүүлэх Зөвлөх мэргэжилтнүүдэд зориулсан ажлын удирдамж болно.

## Агуулга

Оршил.....	2
1. Тайлангийн хураангуй.....	3
2. Агаарын тухай хууль.....	4
2.1. Хууль батлагдах шаардлага.....	4
2.2 Агаарын тухай хуулийн зөрчил, хийдэлтэй заалтууд:.....	5
3. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль.....	12
3.1. Хууль батлагдах шаардлага.....	12
3.2 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн зөрчил, хийдэлтэй заалтууд.....	13
4. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн судалгаа.....	15
4.1. Хууль батлагдах шаардлага.....	16
4.2. Хуулийн зөрчил хийдэл бүхий заалтууд.....	16
5. Холбогдох бусад хуулийн судалгаа.....	17
5.1. Эрүүгийн хууль.....	17
5.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль.....	19
6. Холбогдох хуулиар батлагдах эрх зүйн актууд батлагдсан эсэх.....	21
7. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөн дэх зөвлөмжийн хэрэгжилт.....	27
8. Хавсралтууд.....	31
8.1. Хавсралт 1. Холбогдох хуулиуд.....	31
8.2. Хавсралт 2. Улсын Их Хурлын тогтоол.....	32
8.3. Хавсралт 3. Засгийн газрын тогтоол.....	33
8.4. Хавсралт 4. Олон Улсын гэрээ.....	34
8.5. Хавсралт 5. Сайдын тушаал.....	35
8.6. Хавсралт 6. Агаарын тухай хуультай холбогдох Монгол Улсын стандартууд.....	36
8.7. Хавсралт 7. Цэвэр Агаарын Сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн жагсаалт.....	37
8.8. Хавсралт 8. Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өгөх санал.....	0
Агаарын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7. ....	0
8.9. Хавсралт 9. Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өгөх санал.....	8
“озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих;”.....	8

## Оршил

Европын сэргээн босголтын банк, Монгол Улсын Байгаль орчны яамтай хамтран хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын цэвэр агаар санаачлага II” төслийн хүрээнд Агаарын тухай болон түүнтэй холбоотой бусад хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэх шинээр боловсруулах зорилго бүхий Зөвлөх багийн гүйцэтгэх ажлын хэмжээ, шийдвэрлэх зорилгыг дараахь байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Цэвэр түлшний тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх журам, Агаарын тухай хууль болон түүнийг хэрэгжүүлэх журмыг боловсруулахад шаардлагатай бүх дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. Зөвлөх мэргэжилтэн нь Засгийн газар /Парламентад хуулийн төслийг танилцуулахад шаардлагатай, дэмжлэг болох бүх бичиг баримтуудыг боловсруулахад тусална (дүгнэлт, санамж бичиг гэх мэт) /Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө 3.3.1/:

Зөвлөх мэргэжилтэн нь Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөний холбогдох хэсгүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх хууль, тогтоомжтой уялдуулан боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бүх хууль тогтоомжийн суурь судалгааг хийх, хууль зүйн бүх арга механизмыг (анхдагч, хоёрдахь болон бусад) тодорхойлох. Шаардлагатай бүх бичиг баримт, хуулийн төслийг боловсруулахад туслах эсхүл тэдгээрийн боловсруулалтыг удирдах, дэмжлэг үзүүлэх шаардлагатай хурал, уулзалт, семинар, танилцуулгад оролцох шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ /Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө 3.3.2/ гэж тус тус заасны дагуу энэхүү судалгааг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Агаарын тухай хууль Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль, Агаарын бохирдлыг төлбөрийн тухай, болон холбогдох хуулиудад дүн шинжилгээ хийж, хуулийн заалтуудын бусад хуулийн заалтуудтай зөрчилтэй, давхардалтай, мөн хийдэлтэй тодорхой зохицуулалт шаардлагатай заалтуудыг түүвэрлэн судалсны үр дүнд энэ саналуудыг боловруулсан болно.

## 1. Тайлангийн хураангуй

Төслийн баг нь энэхүү тайланг Агаарын тухай хуультай холбогдох 1992-2011 оны хооронд батлагдаж мөрдөгдсөн нийт 24 хууль, 70 гаруй эрх зүйн актын жагсаалтыг гаргаж үүнээс одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Агаарын тухай хууль, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бусад хуульд судалгаа хийсэн юм.

Судалгаа нь Агаарын тухай хуулийн судалгаа, Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн судалгаа, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн судалгаа холбогдох бусад хуулийн судалгаа зэрэг бие даасан судалгаанууд хамрагдаж байгаа бөгөөд судалгаа тус бүрд тухайн хуулийн хийдэл бүхий заалтууд, бусад хуультай зөрчилдөж буй зүйл заалтууд, бусад хуулийн заалтуудтай давхардсан зохицуулалт зэргийг тодорхойлж тус бүр товч тайлбар хийсэн болно.

Мөн холбогдох бусад хууль тогтоомж гэсэн 4 дүгээр бүлэгт Эрүүгийн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиуд, агаарын тухай Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиудийн холбогдох хэсгүүдэд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох санал зөвлөмжийг боловсруулав.

Судалгааг хийхдээ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлалд заасны дагуу доорх байдлаар ойлгож судалгаанд тусгасан болно. Үүнд:

“Давхардал” гэж хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэл зүйн хувьд хуулбарласан эсхүл тэдгээрийн зохицуулалтын агуулга, зорилго нь ижил байхыг.

“Зөрчил” гэж нэг этгээдийн зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн эрэмбэлэлийн аргын дагуу хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томъёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг.

“Хийдэл” гэж тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг.

Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдсон харилцааг зохицуулж буй нийт гурван хуульд заасан батлагдвал зохих дүрэм, журмыг батлан мөрдүүлэх эрхийг олгосон хуулийн зүйл заалтын жагсаалтыг түүвэрлэн гаргаж батлагдсан эсэх талаар судалгааг хийж гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааг Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн харилцааг зохицуулж буй хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудын уялдаа холбоог сайжруулах, хуулийн заалтыг тодорхой ойлгомжтой болгох зорилгоор ашиглах боломжтой юм.



## 2. Агаарын тухай хууль

### 2.1. Хууль батлагдах шаардлага

2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр Монгол Улсын Их Хурал Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан юм. Үүнээс өмнө 1995 оны 03 дугаар сарын 31-ны өдөр батлагдсан Агаарын тухай хууль хэрэгжиж байсан бөгөөд хуулийн шинэчилсэн найруулгаар өнөөгийн Нийслэлийн агаарын бохирдлын нөхцөл байдал, агаарын бохирдлыг бууруулах шаардлага зэргийг харгалзан шинээр зохицуулалт нэмэх, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, төрийн болон бусад байгууллагуудын эрх үүгийг нарийвчлан зохицуулах шаардлага гарсны хүрээнд энэхүү шинэчилсэн найруулгыг батлан гаргасан болно.

2010 оны 06 дугаар сарын 24-ны өдөр батлагдсан Агаарын тухай хууль нь хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах бөгөөд бүтцийн хувьд 5 бүлэг 26 зүйлтэй.

Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хуульд тусгагдсан нэр томъёог нэг мөр ойлгох зорилгоор нэр томъёоны тодорхойлолтыг оруулж өгсөн бөгөөд өмнө үйлчилж байсан агаарын тухай хуульд тусгагдаагүй байсан Агаарыг хамгаалах талаарх Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, болон аж ахуйн нэгж байгууллагын нийтлэг эрх үүргийг тодорхойлж, агаарыг хамгаалах арга хэмжээ болон агаарын бохирдлын нөхөн төлбөрийн талаарх зохицуулалтуудыг нарийвчилж заасан байна.

Мөн уг Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгад Цэвэр агаарын сангийн талаарх зохицуулалт орсон байх бөгөөд тус сангийн төсвийн ерөнхийлөн захирагч нь байгаль орчны асуудал эрхлэсэн засгийн газрын гишүүн байхаар, сангийн үйл ажиллагааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулахаар хуульчилсан байна. Мөн иргэд аж ахуйн нэгж байгууллагаас төлж буй агаарын бохирдлын төлбөр тус санд төвлөрч байхаар зохицуулжээ.

## 2.2 Агаарын тухай хуулийн зөрчил, хийдэлтэй заалтууд:

- Агаарын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7. “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих үүрэгтэй”

Энэхүү хуулийн заалтад “Төрийн захиргааны төв байгууллага озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих” гэж заасан боловч хэрхэн хяналт тавих арга механизм тодорхойгүй, үе шаттайгаар бууруулах гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй, салаа утгатай зохицуулалт болсон байна. Өөрөөр хэлбэл: Үе шаттай бууруулна гэдэг нь ямар хугацаанд ямар түвшинд хүргэх зорилт нь тодорхой, биелэгдсэн эсэхийг дүгнэж болохоор байх шаардлагатай. Хуулийн зохицуулалт нь хүрэх үр дүн нь маш тодорхой байх ёстой бөгөөд хийсвэр хүрэх үр дүн нь тодорхойгүй зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй юм. Иймд цаг хугацааны хувьд ямар үеийг хамаарч, озон задалдаг бодисын хэрэглээг хэдэн хувиар бууруулахыг тодорхой болгох шаардлагатай байна.

**Санал:** Төрийн захиргааны байгууллага озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах төлөвлөгөөг боловсруулж уг төлөвлөгөөний дагуу ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

Иймд хуульд “Төрийн захиргааны байгууллага озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах төлөвлөгөө боловсруулан уг төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих” гэж зохицуулсан тохиолдолд ойлгомжтой болох юм.

- Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйл. “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг 7 дугаар зүйлийн 7.1.3. “Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох” үүргийн аж ахуйн нэгж байгууллагад ногдуулжээ.

Дээрх хуулийн заалтаар аж ахуйн нэгж байгууллагад үүрэг ногдуулсан хэдий ч үүргээ хэрэгжүүлээгүй бол ямар хариуцлага ногдуулах тухай зохицуулалт байхгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлөх юм.

**Санал:** Хуулийн хэрэгжилтийг хангахын тулд албадлагын механизм буюу үүргээ биелүүлээгүй болон хориглосон зохицуулалтыг зөрчсөн үед хариуцлага ногдуулах зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай байна. Уг хуулийн 26 дугаар зүйлд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон бөгөөд уг зүйлд 7 дугаар зүйлийн 7.1.3-д заасан үүргээ биелүүлээгүй аж ахуйн нэгжид ногдуулах хариуцлагыг хуульчилж өгөх шаардлагатай.

- Агаарын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3. *“Шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага нь дангаараа, эсхүл холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран агаарын бохирдлыг бууруулах, хянах чиглэлээр бусад стандартыг боловсруулж батлуулна”*

Энэхүү зүйл заалтад *“Шаардлагатай тохиолдолд”* гэдэг нь хэт ерөнхий зохицуулалт болсон байна. *“Шаардлагатай тохиолдолд”* гэдэгт ямар тохиолдлууд хамаарахыг хуулийн нэр томъёоны хэсэгт тайлбар оруулах шаардлагатай байна. Төрийн захиргааны төв байгууллага онцгой нөхцөл байдал үүссэн хэдий *“Шаардлагатай тохиолдол”* гэж үзэхгүй бол стандарт боловсруулахгүй байх боломжтой бөгөөд ингэсэн тохиолдолд ямар нэгэн хариуцлага тооцох боломжгүй болж байгаа юм.

**Санал:** Төрийн захиргааны төв байгууллага зайлшгүй батлах шаардлагатай стандартын жагсаалтыг судалгааны үндсэн дээр жил бүр гаргах, үүний дагуу стандарт гаргахаар хуульчилах нь зүйтэй гэж үзэж байна.

- Агаарын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4. *“Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байвал зохино”*

Энэхүү заалт нь аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтэрсэн тохиолдолд хэн, ямар шийдвэрийн дагуу хариуцлага тооцох тухай зохицуулалтыг бий болгоогүй байна.

**Санал:** Аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтэрсэн тохиолдолд хэн, ямар шийдвэрийн дагуу хариуцлага тооцох зэрэг асуудлыг хуульчлан оруулах зүйтэй гэж үзэж байна.

- Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйл. *“Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр<sup>1</sup> ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ мэргэжлийн албаар дүгнэлт гаргуулан сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна”* гэж заажээ.

Харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтад *“Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглахдаа сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна”* гэж заасан байна. Агаарын тухай хуулиар зөвхөн *“Томоохон суурин эх үүсвэр”* ашиглахад тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу агаарт бохирдуулах бодис гаргаж, физикийн хортой нөлөөлөл үзүүлж байгаа бол ямар ч ялгамжгүйгээр бүгд тусгай зөвшөөрөл авахаар заасан нь илүү өргөн хүрээг хамарч байх тул эдгээр заалтууд зөрчилдөх үндэслэл болж байна.

**Санал:** Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлд *“Энэхүү 5 дугаар зүйлийн 5.1.8-д зааснаас бусад тохиолдолд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр<sup>2</sup> ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ мэргэжлийн албаар дүгнэлт гаргуулан сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна”* гэж оруулах, Мөн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтад Агаарын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8-д зааснаас бусад тохиолдолд агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин

<sup>1</sup> *“Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр гэж хүрээлэн байгаа агаарт жилд 100 тонноос их аливаа нэг бохирдуулах бодис, эсхүл 5 тонноос их аюултай бохирдуулах бодис гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалтын барилга байгууламжийг ойлгоно”* гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтанд заасан.

<sup>2</sup> *“Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр гэж хүрээлэн байгаа агаарт жилд 100 тонноос их аливаа нэг бохирдуулах бодис, эсхүл 5 тонноос их аюултай бохирдуулах бодис гаргадаг үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалтын барилга байгууламжийг ойлгоно”* гэж Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8 дахь заалтанд заасан.

эх үүсвэр ашиглахдаа сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна” гэж нэмж оруулбал тодорхой болох юм.

- Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “*Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т<sup>3</sup> заасан бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг төрийн захиргааны төв байгууллага батална*” гэж заасан байхад тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтанд “Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтооно” гэж зөрчилдсэн байна.

Өөрөөр хэлбэл Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт хаягдлын хэмжээг хэрхэн, ямар аргачлалаар, яаж тогтоох арга механизмыг журамлах зохицуулалт гэж ойлгогдохоор хуульчилсан байхад мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтанд “*Хаягдлын хэмжээг тогтооно*” гэж заасан нь зөрчилдсэн байна. “*Хэмжээг тогтоох*”, “*Хэмжээ тогтоох журмыг тогтоох*” гэдэг нь ялгаатай ойлголт юм.

**Санал:** Агаарын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8. “*Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтооно*” гэснийг “*Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг тогтооно*” гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Эсхүл зөвшөөрөгдөх хаягдлыг, мөн зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журам хоёуланг Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоох бол үүнийг ялгааг тодруулан хуульчлах нь зүйтэй.

- Агаарын тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.1. Агаар дахь бохирдуулах бодисын агууламж, физикийн сөрөг нөлөөллийн түвшин нэмэгдэж, стандартад заасан хүлцэх хэм хэмжээнээс хэтэрсэн нь хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулахаар болсон бол тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, мэргэжлийн алба энэ тухай аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, хүн амд шуурхай мэдэгдэнэ”, мөн зүйлийн 14 дүгээр зүйлийн 14.2-д “*Агаарын бохирдол, физикийн сөрөг нөлөөлөл нэмэгдсэн шалтгааныг тогтоох, хохирлыг арилгах арга хэмжээг аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, мэргэжлийн алба, бүх шатны Засаг дарга, холбогдох эрүүл ахуйн болон бусад байгууллага хамтран яаралтай авч хэрэгжүүлнэ*” 15 дугаар зүйлийн 15.1- д “*Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн байгаль цаг уурын нөхцөлөөс шалтгаалан агаарын бохирдол ихсэж болзошгүй тухай мэдээг мэргэжлийн албанаас хүлээн авмагц өөрийн эзэмшлийн агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодис, үзүүлэх физикийн сөрөг нөлөөллөө багасгах талаар дээр дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ*” гэж тус тус зохицуулан заасан байна.

Гэвч ийнхүү мэдэгдээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульчлаагүй тул энэхүү зохицуулалт нь хэрэгжихэд хүндрэлтэй юм.

**Санал:** Агаарын тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд албадлагын механизм буюу үүргээ биелүүлээгүй болон хориглосон зохицуулалтыг зөрчсөн үед хариуцлага ногдуулах зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай байна. Уг хуулийн 26 дугаар зүйлд хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон бөгөөд уг зүйлд 14 дугаар зүйлийн 14, 15 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй Засаг дарга болон аж ахуйн нэгжид авах хариуцлагыг хуульчилж өгөх шаардлагатай.

- Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 “*Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандарт, физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоох буюу үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх*

<sup>3</sup>“Агаарын тухай хууль”-ийн 13 дугаар зүйлийн 13.2-т “Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасан зөвшөөрөлд тухайн эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдал, үзүүлэх физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээг зааж, агаарыг хамгаалах талаар авах арга хэмжээ, хууль хууль тогтоомжинд заасан бусад шаардлагыг тусгана” гэжээ.

*саналыг байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад тавих бөгөөд уг саналыг эрх бүхий байгууллага 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ”*

Уг заалтын утга нь зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамааралтай зохицуулалт болсон байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд “Тусгай зөвшөөрлийг зогсоох” гэсэн ойлголт байхгүй бөгөөд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд “Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ”, харин удаа дараа зөрчсөн бол “Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгодог”. Мөн “Үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх” гэсэн хуулийн зохицуулалт тус хуульд байхгүй. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд бусад тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохицуулж байгаа бусад хууль нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл: Агаарын тухай хуульд “Тусгай зөвшөөрлийг зогсоох, үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх” гэж заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдсөн байна.

**Санал:** Эдгээр хоёр хуулийн хариуцлага тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамаарч байгаа тул зөрчилдсэн зүйл заалтыг өөрчилж Тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан хариуцлагыг оногдуулахаар зохицуулах нь зүйтэй гэж үзэж байна.

- Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт “ Зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах болон хог хаягдал устгах стандартын шаардлага хангаагүй аливаа үйл ажиллагааг хориглоно” гэж заасан нь Ариун цэврийн тухай хуулийн зохицуулалттай <sup>4</sup> давхардуулсан байна.
- Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 “Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартыг үндэслэнэ”

Энэхүү зохицуулалт ямар нэг хууль зүйн үр дагавар үүсгэхгүй байна. Хэрэв дээр дурдсан стандартад үндэслээгүй барилга байгууламжийн байршлыг сонгосон, зураг төсөл зохиосон, барьсан гэх мэт хуульд заасан үйлдлүүд хийсэн бол ямар хууль зүйн үр дагавар үүсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл: Уг барилга байгууламжийг барих ажлыг зогсоох гэх мэт уг хуулийн хэрэгжилтийг хангах дараагийн арга хэмжээ хуульд тусгагдсан байх шаардлагатай. Иймд уг зохицуулалтыг цаашид хэрэгжих механизмыг тодорхой болгох шаардлагатай байна. Тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтанд “...агаарыг хамгаалах шаардлага хангаагүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, техник, технологи нэвтрүүлсэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг наймаас ес дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”-оор санкц ногдуулсан нь хууль зөрчсөн тохиолдолд зөвхөн 700000-1300000 төгрөгөөр торгохоор байгаа нь уг хориглосон зохицуулалт ач холбогдолгүй болж байна. Нэгэнт уг стандартын дагуу зураг төслөө хийгээгүй, барилга байгууламж барьсаны дараа хариуцлага тооцох заалт байгаа юм.

**Санал:** Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх,

<sup>4</sup> 7 дугаар зүйл. Хөрсний ариун цэвэрт тавих шаардлага

7.3.Эмнэлийн байгууллагын тусгай хог хаягдлыг болон нянгийн өсгөөр, цацраг идэвхт болон химийн хортой бодис ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ явуулдаг байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хог хаягдлаа мэргэжлийн хяналтын байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр хог хаягдлын нийтийн цэг дээр хаяхыг хориглоно.

7.4.Хог хаягдлын тогтоосон цэгээс өөр газарт хог хаягдал хаях, орчныг бохирдуулахыг хориглоно.

7.5.Хүн, мал, амьтанд халдвар тараах, байгаль орчинд хор хөнөөлтэй хог хаягдлыг тогтоосон тусгай цэгт булшлах буюу устгана.

ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартыг үндэслэх бөгөөд стандартын дагуу хийгдээгүй зураг төсөлд барилгын ажил эрхлэх зөвшөөрөл олгохгүй, мөн барилгын ажил эхэлсэн тохиолдолд барилгын ажлыг зогсоох хүртэлх арга хэмжээ авахаар хуульчлах нь зүйтэй.

Мөн дээрхи хуулийн зохицуулалтуудыг барилгын асуудлыг зохицуулсан хууль болох Барилгын тухай хуультай уялдуулж дээрхи бүх тавигдах шаардлагуудыг тус хуульд нэмж тусгах шаардлагатай гэж үзэж байна.

- Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т *“Агаарт онцгой хорттойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих асуудлыг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ”*

*“Агаарт онцгой хорттойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламж”* гэдэгт нь ямар үйлдвэрлэл үйлчилгээний барилга байгууламж хамаарах нь тодорхойгүй байгаа энэхүү заалт хэрэгжихэд хүндрэлтэй юм.

**Санал:** Хуулийн нэр томъёоны хэсэгт *“Агаарт онцгой хорттойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламж”* гэснийг хэрхэн ойлгох талаар тайлбар хийх нь зүйтэй байна. Эсхүл шалгуурыг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна.

- Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4. *“Суурин газрын агаарыг хамгаалах зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хүн амын суурьшлын бүсээс зааглах бөгөөд уг бүсийн хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, төрөл бүрээр тогтоосон жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална”*

Уг жагсаалт одоогоор батлагдаагүй байна.

**Санал:** Уг жагсаалтыг батлах шаардлагатай. Гэхдээ энэхүү журамд одоогийн хотын барилга байгууламж баригдсан нөхцөл байдлыг харгалзан үзэж тухайн барилга байгууламжид тохируулан тогтоохгүй бол нэгэнт баригдаж байгаа барилга байгууламжийг өөрчлөхөд хүндрэл учирч болзошгүй юм.

- Агаарын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1. *“Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална”*

Тусгай зөвшөөрөл олгох харилцааг зөвхөн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн болон бусад хуулиар зохицуулдаг. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөллийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1. *“Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэргэжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино”* гэж заасан байх бөгөөд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг уг хуулиар зохицуулах эрх зүйн үндэслэл бий болж байгаа юм. Гэтэл *“Тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална”* гэж заасан нь хууль зөрчсөн байна.

**Санал:** Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрлийг Тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгохоор заах нь эрх зүйн зохицуулалтын хувьд тохиромжтой байна.

- Агаарын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. *“Озон задалдаг бодисыг юүлэх, дахин боловсруулах, тоног төхөөрөмжийг дахин цэнэглэх зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно”* гэж заасан байна.

Харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.1. *“Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах”* зөвшөөрөл гэж заасан нь зөвшөөрөл олгох үйл ажиллагааны хувьд өөрөөр журамласан зөрчилтэй байна.

**Санал:** Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны нэр томъёог адилтгаж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

- Агаарын тухай хуулийн 17 дугаар зүйл. *“Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хот, тосгон, бусад суурин газрын байршил, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа агаарын төлөв байдалд гарч болох өөрчлөлт, болзошгүй сөрөг нөлөөллийг харгалзана, төлөвлөгөөг төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан зөвшөөрөл авна”*

**Санал:** Энэхүү заалтыг бүрэн хэрэгжүүлэхийн тулд Газрын тухай хуульд хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл, газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох төрийн захиргааны төв байгуулгаар хянуулан зөвшөөрөл авна гэсэн зохицуулалтыг нэмж тусгах шаардлагатай байна.

- Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1. *“Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ эх үүсвэр нэг бүрээ хянах дотоод хяналтын багаж хэрэгсэл болон агаар бохирдуулах бодисыг саармагжуулах, цэвэрлэх, физикийн сөрөг нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмжөөр тоноглоно”*

Энэхүү зохицуулалт нь зохицуулалт тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалттай<sup>5</sup> давхардсан утгатай байх бөгөөд уг төхөөрөмжөөр тоноглоогүй буюу хуулийг биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгаагүй байна.

Мөн *“Агаар бохирдуулах бодисыг саармагжуулах, цэвэрлэх, физикийн сөрөг нөлөөллийг бууруулах тоног төхөөрөмж”* гэдэгт ямар тоног төхөөрөмж хамаарах талаар хуульд тодорхойлолт нэмж тусгах шаардлагатай байна. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглох, тэдгээрийн ашиглалтын байдалд тухайн салбарыг харьяалах төрийн захиргааны төв байгууллага, сум, дүүргийн Засаг дарга, байгаль орчны улсын байцаагч хяналт тавина гэж хяналтын чиг үүргийг дээрхи 3 байгууллага, албан тушаалтанд давхардуулан хуульчилсан байна.

**Санал:** Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхдээ эх үүсвэр нэг бүрээ хянах дотоод хяналтын багаж хэрэгсэл болон агаар бохирдуулах бодисыг саармагжуулах, цэвэрлэх, физикийн сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй шаардлага бүхий тоног төхөөрөмжийн жагсаалтийг журмаар батлах шаардлага зүй ёсоор гарч байна. Эсхүл уг тоног төхөөрөмж нь агаарыг ямар хэмжээгээр бууруулах хүчин

<sup>5</sup> 7 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний эрх, үүрэг

7.1.3. агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох.

чадал бүхий тоног төхөөрөмж байх талаарх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох шаардлагатай.

- Агаарын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1. *“Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт бохирдуулах бодисыг бохирдуулах бодисын хаягдлын стандартад заасан хэмжээнээс хэтрүүлэн гаргасан тохиолдолд мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны байцаагч, холбогдох сум, дүүргийн Засаг дарга учирсан хохирлыг арилгуулж, хохирлын хэмжээг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр агаарын бохирдлын нөхөн төлбөр ногдуулан, төлөлтөд нь хяналт тавина”*

Өөрөөр хэлбэл торгуулийн хэмжээ нь хохирлын хэмжээгээр үнэлэгдэж байна. Энэ тохиолдолд учирсан хохирлыг хэрхэн тооцох талаар маргаантай асуудал үүсэж болох юм. Хохирлыг тооцох нэгдсэн жишиг, арга зүйг батлан гаргахгүй бол агаарын бохирдлоос бий болсон хохирлыг өөр өөрөөр тогтоож, шударга бус байдал бий болж болзошгүй байна.

**Санал:** Уг хуулийн хариуцлагыг хохирлын хэмжээнээс үл хамааран тогтоосон тодорхой үнийн дүнгээр тооцох, эсхүл агаар бохирдуулснаас байгаль орчинд учирсан хохирлыг хэрхэн тооцох, хэрхэн арилгуулах талаарх журам стандартыг батлан мөрдүүлэх шаардлагатай.



## 3. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль

### 3.1. Хууль батлагдах шаардлага

Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн төвшин гамшгийн хэмжээнд хүрч тоосонцорын хэмжээгээр дэлхийн хамгийн бохирдолтой хот болоод байгаа бөгөөд түүхий нүүрсний шаталтаас үүдэлтэй утаа тортог, бохирдлын хэмжээ ДЭМБ-ын зөвлөмж хэмжээ Агаарын чанарын үндэсний стандартаас 10-20 дахин хэтэрч, хүйтний улиралд бүх өдрүүдэд агаар дахь тоосонцор, хүхэрлэг хий зэрэг хорт бодисын агууламж Агаарын чанарын стандартаас давж байна. Үүнтэй холбогдуулан Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийг тусад нь батлан гаргах шаардлага гарсан юм.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан бөгөөд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа юм. Уг хууль нь бүтэцийн хувьд 4 бүлэг 14 зүйлтэй.

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулиар нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг тодорхойлж, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоох, аргаарын бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог дэмжих зорилгоор урамшуулалын арга хэмжээ авах, агаарын бохирдлыг бууруулахад төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэн аж ахуйн нэгжийн эрх үүргийг тодорхойлсон бөгөөд мөн хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтуудыг оруулсан байна.

### 3.2 Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн зөрчил, хийдэлтэй заалтууд

Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад дараахь үйл ажиллагааг тодорхой үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

- Эрчим хүчний эх үүсвэр, гэр хорооллын цахилгаан дамжуулах болон түгээх сүлжээг өргөтгөх, хүчин чадлыг нэмэгдүүлэх.
- Гэр хороололд агаарын чанарыг сайжруулах бүс тогтоож, эрчим хүчний үнийг урамшууллын хэлбэрээр зохицуулах.
- Гэр хорооллын айл өрхөд шаардлагатай эрчим хүчний болон бусад хөнгөлөлт, үйлчилгээг хүргэх ажлыг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх.
- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, шинэ санаачилга гаргасан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх.
- Гэр хорооллын айл өрхийн газрыг барьцаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар уул уурхайн баялгаас бий болох хөрөнгөөс урт хугацаатай, бага хүүтэй зээлийг олгож үл хөдлөх эд хөрөнгө, барилга, орон сууц барих бололцоо нөхцөл бүрдүүлэх.
- Орон нутагт хөрөнгө оруулалт, ажлын байр нэмэгдүүлэх, бүсийн нэмэгдлийг бий болгож айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг нийслэлээс орон нутагт шилжих таатай нөхцөл бүрдүүлэх.
- Бүсчилсэн хөгжлийн тулгуур төв болон нийслэлийн алслагдсан дүүргийг хөгжүүлэх бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж, нийслэлийн хүн амын төвлөрлийг сааруулах.

Дээрхи бүх зохицуулалтуудад нь хэн, хэрхэн, ямар хугацаанд хэрэгжүүлэх буюу хэрэгжих арга механизм нь тодорхойгүй зохицуулалт болсон байна. Агаарын бохирдлыг бууруулахад үе шаттайгаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа болгонд уг үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, арга хэмжээнүүд, хэрэгжүүлэх субъектүүд, зэргийг тодорхойлсон төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай бөгөөд энэхүү төлөвлөгөөг боловсруулах эрх бүхий субъектыг мөн тодорхойлох ёстой билээ. Ингэсэн тохиолдолд хуулийн заалт хэрэгжих боломжтой болох юм.

**Санал:** Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулахад хийгдэх үйл ажиллагаанууд тус бүрт төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтэд хяналт тавих субъектийг тодорхойлох, мөн хэрэгжүүлэх үйл ажиллагааг явуулах субъектыг тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна.

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1. *“Дараахь нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан айл өрхөд энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан урамшуулал олгоно”* гэж заагаад шалгууруудыг тодорхойлжээ.

Гэтэл тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтанд *“Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хороололын энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан айл өрхөд цахилгаан, эрчим хүчний үнийг 50 хувиар бууруулах урамшууллын арга хэмжээг авч, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх”* гэж зохицуулсан дээрх 6 дугаар зүйлд заасан заалттай зөрчилдсөн байна.

Хуулийн 6 дугаар зүйлд зааснаар шалгуурыг хангаж байгаа тохиолдолд нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарч байгаа эсэхээс үл хамааран хөнгөлөлт эдлэх

боломжтойгоор зохицуулсан байхад 10 дугаар зүйлийн 10.1.4-д зөвхөн *“Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрх”*-үүдэд урамшуулал олгохоор зохицуулсан нь ойлгомжгүй нөхцөл байдлыг бий болгож байна.

**Санал:** Иймээс 10 дугаар зүйлийн 10.1.4-д заасан заалтыг 6 дугаар зүйлд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1. *“Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаах”* 7 дугаар зүйлийн 7.1.2 *“Зориулалтын бус газарт хог хаягдал хаях, ил задгай шатаах, агаар бохирдуулах бодис ялгаруулдаг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх”* 7 дугаар зүйлийн 7.1.3 *“Урамшуулал бүхий цахилгаан эрчим хүчийг ахуйн зориулалтаас бусад хэлбэрээр ашиглах”* 7 дугаар зүйлийн 7.1.4. *“Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4-т заасан урамшуулал бүхий цахилгаан эрчим хүчийг ахуйн зориулалтаас бусад хэлбэрээр ашиглах”* 7 дугаар зүйлийн 7.1.5-д *“Стандартын шаардлага хангаагүй цахилгаан халаах хэрэгсэл ашиглах”*-ыг тус тус хориглосон.

Дээрхи хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгаагүй байна. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаахыг хориглосон байна. Харин тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалт нь *“Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйлс шатаахгүй байх”* үүрэгтэй гэж заасан нь зөрчилтэй зохицуулалт болжээ. Түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйлс шатаахыг хориглосон зохицуулалтын хувьд *“Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд”*, *“Нийслэлийн нутаг дэвсгэрт”* гэж 2 өөр бүс нутгийг хамруулсан зөрчилтэй байна.

**Санал:** Хуулийн 7 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох, мөн Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд, эсхүл Нийслэлийн нутаг дэвсгэрийн яг алинд нь түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйлс шатаахгүй байхаар зохицуулж байгааг тодорхой болгохгүй бол хэрэгжихэд хүндрэл учирна.

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1. *“Ерөнхийлөгч нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороог байгуулж ажиллуулах”*

Харин Агаарын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтанд *“Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага агаарыг хамгаалах талаархи төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах бүрэн эрхтэй”* гэж заасан байна. Дээрхи хуулийн заалтуудаас үзэхэд Үндэсний хороо болон Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын агаарыг хамгаалах талаархи зарим чиг үүргүүд давхардсан байна. Эдгээр бүрэн эрхийг тус тусад нь нарийвчлан тодорхойлж хуулинд тусгахгүй бол хэрэгжилтэнд нь хүндрэл учирна.

**Санал:** Үндэсний хорооны бүрэн эрхийг тодорхойлж хуульчлах шаардлагатай.

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2. *“Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллага түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад зүйлс шатаахгүй байх агаарын бохирдлыг бууруулах техник, технологи, шингэрүүлсэн хийн түлш, бусад эх үүсвэрийг ашиглах үүрэгтэй”*

Хэдийгээр ийнхүү үүргийг тодорхойлсон ч энэхүү хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол хүлээлгэх хариуцлагыг хуульд тусгаагүй байна. Иймээс уг хуулийн заалт хэрэгжихэд хүндрэлтэй болж байна.

**Санал:** Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-д заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ямар хариуцлага ногдуулахыг тодорхойлох шаардлагатай.

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1. *“Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль тогтоомжид заасан бүрэн эрх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол тухайн шатны албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан арга хэмжээ авна”*

Дээрх хуулийн заалтын *“Хангалтгүй биелүүлсэн”* гэдэгт ямар тохиолдол хамаарах нь энэ хууль болон төрийн албаны тухай хуульд тусгагдаагүй байна. Хуулийн зохицуулалт бүх хүнд ижил, нэг л утгаар ойлгогдох ёстой. Хуулийн зохицуулалт тодорхойгүй, хүн бүр өөрийн үзэмжээр тайлбарлаж болохоох хийдэлтэй байх нь хууль хэрэгжихгүй байх, эсхүл хуулийг буруугаар хэрэглэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог. Иймд хуулийн зохицуулалт ойлгомжтой, шууд нэг утгаар ойлгогдож, хэрэглэгдэж байх ёстой.

**Санал:** Хуулийн заалтыг тодорхой болгох шаардлагатай. Хангалтгүй биелүүлсэн гэдгийг хэн тодорхойлох, ямар шалгуураар тогтоох нь тодорхойгүй байх тул уг заалт нь хэрэгжихэд хүндрэлтэй байх тул Хангалтгүй биелүүлсэн гэдгийг хасах шаардлагатай.

- Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3. *“Энэ хуулийг зөрчиж хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хохирол учруулсан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу хохирлыг нөхөн төлүүлнэ”*

Энэхүү заалтын *“Хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд ноцтой хохирол учруулсан”* гэдгийг хэрхэн тодорхойлох нь ойлгомжгүй байх юм.

**Санал:** Хохирол учирсан тохиолдолд ямар хэмжээнээс дээшхи хохирол учирсан байх эсхүл хүний амь нас хохирсон, эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтлийн аль нь учирсан байхад ноцтойд тооцохыг хуульчлах шаардлагатай байна.

## 4. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн судалгаа

#### 4.1. Хууль батлагдах шаардлага

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулж 2010 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр өргөн мэдүүлсэн бөгөөд Улсын Их Хурал 2010 оны 6 дугаар сарын 24-ны өдөр баталжээ.

Агаарын бохирдлын эх үүсвэр, объект, бохирдуулагч этгээдэд төлбөр ногдуулж бохирдлоос урьдчилан сэргийлэх, бохирдлыг бууруулах арга хэмжээ авах, агаарын чанарт хяналт тавих, экологид ээлтэй цэвэр түлшний үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийн эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад шаардагдах зардлыг нөхөх сан бий болгох зорилгоор агаарын бохирдлын төлбөр төлдөг байх хариуцлагын тогтолцоог бий болгох бодит шаардлагын дагуу уг хуулийн төслийг боловсруулж баталсан байна.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль нь агаарын бохирдлын төлбөр, нөхөн төлбөр ногдуулах, тухайн төлбөрийг төлөх харилцааг зохицуулах бөгөөд нийт 10 зүйлтэй.

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль нь агаарын бохирдлын төлбөр төлөгчийг бүртгэх, агаарын бохирдлын төлбөр ногдох зүйлийг тодорхойлох, төлбөр ногдуулах биет нэгжийг тодорхойлох, төлбөрийн хувь хэмжээ, төлбөрөөс чөлөөлөх хөнгөлөх нөхцөл, төлбөр төлөгч төлбөр төлөх тайлагнах журам, хууль тогтоомж зөрчигсдөд хүлээлгэх хариуцлага зэрэг зүйлүүдийг зохицуулсан байх бөгөөд өмнө нь Монгол улсад мөрдөгдөж байгаагүй шинэ харилцааг зохицуулсан хууль юм.

#### 4.2. Хуулийн зөрчил хийдэл бүхий заалтууд

- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3. *“Аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагч нь агаарын чанарын мэргэжлийн албатай хамтран төлбөр төлөгчийн ашиглаж байгаа агаарын бохирдлын эх үүсвэрийн нэр, байршил, улсын бүртгэлийн дугаар, төрөл, тоног төхөөрөмжийн хүчин чадал, ашиглалтын хугацаа болон бусад шаардлагатай гэж үзсэн мэдээллийн бүртгэл хөтөлнө”*

Энэхүү заалт нь хэт ерөнхий зохицуулалт болжээ. Аймаг нийслэлийн татварийн алба бүртгэлтэй холбоотой ямар үйл ажиллагааг, ямар эрх хэмжээний хүрээнд явуулах, дүүргийн татварийн газар, хэлтэс ямар үйл ажиллагааг ямар эрх хэмжээний хүрээнд явуулах, сумын татварын тасаг ямар үйл ажиллагаа явуулах, татварын байцаагч ямар эрх хэмжээний хүрээнд ямар үйл ажиллагаа явуулах зэрэг нь тодорхойгүй байна. Эдгээр олон байгууллага, албан тушаалтнуудын яг аль нь бүртгэлийг хөтлөх, уг бүртгэлийг хэн ямар зориулалтаар ашиглаж болох, бүртгэгдсэн байгууллага аж ахуйн нэгж нь бүртгэлд авагдсан мэдээллийг зөвшөөрөхгүй, өөрчлөлт оруулах бол ямар журмаар оруулах зэрэг маш олон зүйл тодорхойгүй нөхцөл байдлууд бий болж байгаа юм. Мөн хуулийн заалтанд заагдсан *“Бусад шаардлагатай гэж үзсэн мэдээлэл”* гэдэг нь ерөнхий тодорхойлох боломжгүй заалт байна.

**Санал:** Бүртгэл хөтлөх үйл ажиллагааг тодорхой болгож хуулийн заалтад заагдсан байгууллагуудын бүртгэлийн үйл ажиллагаа явуулах журмыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэж үзэж байна. Мөн бүртгэлд зайлшгүй байх шаардлагатай мэдээллийг нэг бүрчлэн оруулах нь зүйтэй байна.

- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5. *“Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасан иргэн аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр авах журам төлбөрийн хувь хэмжээг Засгийн газар тогтооно”*

Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д *“Агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага”* нь агаарын бохирдлын төлбөр төлөгч байхаар заасан байдаг. Татварын Ерөнхий хуулийн 8 дугаар

зүйлийн 8.4.- д зааснаар Засгийн газар нь энэ хуулийн агаарын бохирдлын төлбөрийн хувь, хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан тогтоохоор зохицуулсан байна.

Гэтэл дээрх Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-д зааснаар агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах төлбөрийн хэмжээг Засгийн газар шууд тогтоохоор заасан нь Татварийн Ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасантай зөрчилдөж байгаа юм. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-д заасан төлбөр нь агаарын бохирдлын төлбөр мөн бөгөөд уг төлбөрийн хэмжээний хязгаарыг Улсын их хурлаас тогтоогоогүй байх бөгөөд хуулинд зааснаар төлбөрийн хувь хэмжээг Засгийн газар тогтоохоор хуульчилсан нь хуулийн зохицуулалтын зөрчилдөх үндэслэл болж байна.

**Санал:** Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулинд Агаарт бохирдол гаргах эх үүсвэр хэрэглэж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авах төлбөрийн хязгаарыг тогтоох нь зүйтэй байна.

## 5. Холбогдох бусад хуулийн судалгаа

### 5.1. Эрүүгийн хууль

2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Эрүүгийн хуулийн 202 дугаар зүйлд “Агаар бохирдуулах” гэсэн гэмт хэргийг тодорхойлсон байдаг.

Эрүүгийн хуулийн 202 дугаар зүйлийн 202.1-д “*Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас ялгарсан хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисыг цэвэршүүлэлгүй хаясан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ*” гэж заасан байна.

Хэрэв агаарыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисоор бохирдуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасах буюу хасахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зуун нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр энэ хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол хоёроос дээш таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр тус тус зохицуулсан байна.

Дээрх агаар бохирдуулах гэмт хэргийн объектив талын шинж нь “*Үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас ялгарсан хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисыг цэвэршүүлэлгүй хаясан*” гэх үйлдэл байна.

Хүндрүүлэх нөхцөл байдал нь “*Агаарыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисоор бохирдуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол*”, “*Хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол*” гэх шинжүүдийг тодорхойлжээ.

Эрүүгийн хуулийн 202 дугаар зүйлд гэмт хэргийн объектив талын шинжид хамаарах “*Үйлдвэрийн үйл ажиллагаа*” гэдэгт химийн хорт бодисыг түүхий эд болгон ашигладаг малын гаралтай арьс шир, ноос ноолуур боловсруулах, алт бусад ашигт малтмал олборлох, барилгын материал боловсруулах зэрэг үйлдвэрүүдийн ажиллагаа хамаарахаар онолын хувьд тодорхойлдог. Харин уг ойлголтыг тайлбарласан албан ёсны дээд шүүхийн тайлбар байхгүй байна.

Байгаль орчинд хортой бодисын талаар:

- 2006 оны 05 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан “*Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль*”
- Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 04/04 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “*Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлал*” болон бусад дүрэм журмаар тус тус зохицуулсан.

Дээрх зохицуулалтад үйлдвэрлэл болон ахуйн үйл ажиллагааны улмаас гарч буй утаа нь химийн хорт болон байгаль орчинд хортой бодист хамаарч байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Хэрэв их хэмжээний утаа ялгарах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хэрхэн цэвэршүүлэх арга стандартыг тодорхойлоогүй, мөн түлшинд тавигдах шаардлага тодорхойлогдоогүй зэргээс хамаарч энэхүү Эрүүгийн хуулийн 202 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт их хэмжээний утаа ялгаруулж агаар бохирдуулж буй үйлдвэр, байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн хариуцлага хүлээх боломжгүй болоод байгаа юм.

Эрүүгийн хуулийн 202 дугаар зүйлийн 202.2-д заасан “*Агаарыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой бодисоор бохирдуулсны улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан бол*” гэх нөхцөл байдлыг Улаанбаатар хоттой адил хот суурин газарт тодорхойлох боломжгүй юм.

Улаанбаатар хотын агаарыг бохирдуулж байгаа утаа нь гэр хорооллын бүхий л айлууд болон автомашин, үйлдвэр зэрэг маш олон газруудын нөлөөнөөс хамаарч байгаа тохиолдолд тодорхой нэг этгээдээс болж хохирол учирсан гэж үзэх үндэслэлгүй юм.

Иймээс Улаанбаатар хотод их хэмжээний утаа ялгаруулж байгаа этгээдэд эрүүгийн хариуцлага тооцох боломжгүй байна.

## 5.2. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль

Засгийн газрын Тусгай сангийн тухай хууль нь 2006 оны 06 дугаар сарын 29-ны өдөр батлагдсан. Энэхүү хуулийн зорилт нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Тус хуулинд:

- 2007 оын 01 дүгээр сарын 11-ны өдөр
- 2007 оны 02 дугаар сарын 06-ны өдөр
- 2007 оны 07 дугаар сарын 09-ны өдөр
- 2009 оны 02 дугаар сарын 13-ны өдөр
- 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр
- 2009 оны 11 дүгээр сарын 18-ний өдөр
- 2010 оны 06 дугаар сарын 24-ний өдөр
- 2010 оны 12 дугаар сарын 02-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт орсон.

2010 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр Засгийн газрын тусгай сангийн төрөлд уг хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.29-д Цэвэр агаарын санг нэмж оруулсан байна.

Уг хуулиар Засгийн газрын 30 төрлийн тусгай сан байхаар зохицуулсан. Эдгээр 30 төрлийн тусгай сан нь:

- Тусгай хуулиар зохицуулах сан
- Эх үүсвэрийг нь 100 хувь төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан
- Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан
- Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг буцалтгүй тусламж, хандиваар бүрдүүлэх сан гэсэн 4 үндсэн ангилалд хуваасан байна.

Цэвэр агаарын сан нь “Эх үүсвэрийнх нь зонхилох хэсгийг төсвийн хөрөнгөөр бүрдүүлэх сан” гэсэн ангилалд хамаарахаар зохицуулсан байна. Цэвэр агаарын сангийн хөрөнгө нь дараахь нийтлэг эх үүсвэрээс бүрдэхээр хуульд зохицуулжээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө
- Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн буцалтгүй тусламж, хандив
- Гадаад улс, олон улсын байгууллагаас Засгийн газрын шугамаар олгосон зээл.

Мөн эдгээрээс гадна агаарын бохирдлын төлбөр, нөхөн төлбөр болон бусад орлогоос сангийн хөрөнгө бүрдэхээр зохицуулсан байна.

Харин тус сангийн хөрөнгө нь дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулагдахаар заасан байна.

- Агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн шинэ дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.



- Стандартын шаардлагад нийцсэн цэвэр түлш, зуух үйлдвэрлэхийг дэмжих, тэдгээрийг худалдан авахад татаас олгох.
- Агаарын чанарын хяналт-шинжилгээний чадавхийг бэхжүүлэх, агаарын чанарын төлөв байдлын хувьсал өөрчлөлтийг тогтоох болон агаарыг хамгаалахтай холбогдолтой стандарт, норм, дүрэм, арга, аргачлал боловсруулах, судалгаа, шинжилгээний төсөл, ажлыг гүйцэтгэх.
- Эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, барилгын дулаалгыг сайжруулах төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.
- Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн иргэд, олон нийтийн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх.
- Сэргээгдэх эрчим хүч, цэвэр технологийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх.
- Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн олон нийтэд мэдлэг олгох сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах.

Цэвэр агаарын сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийг уг хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-д зааснаар Засгийн газар гаргана. Мөн тусгай сангийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь тусгай сангийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.2-т заасан тайланд тусган санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэхээр зохицуулсан байна.

#### **Засгийн газрын тусгай сангийн тухай хуультай холбогдох хуулиуд:**

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
3. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
4. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль
5. Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
6. Төрийн албаны тухай хууль.

#### **Зохицуулалтын талаар:**

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д олон улсын гэрээний дагуу байгуулагдсан сангийн хөрөнгийн эх үүсвэрийг зохицуулсан байх бөгөөд уг зүйлийн 7 дугаар зүйлийн 7.2.5-д “Бусад эх үүсвэр” гэсэн зохицуулалтыг оруулжээ. Мөн хуулийн 12 дугаар зүйлд Цэвэр агаарын сангийн хөрөнгийн эх үүсвэрийн талаарх зохицуулалт байх бөгөөд 12<sup>1</sup> дугаар зүйлийн 12.1.2-д “Бусад орлого”, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3-д “Бусад орлого”, 14 дүгээр зүйлийн 14.5.7-д “Хуульд заасан бусад арга хэмжээ” гэх мэт зохицуулалтууд орсон бөгөөд энэхүү бусад орлого, бусад арга хэмжээ гэх мэт хуулийн зохицуулалт нь ойлгомжгүй, чухам ямар орлогыг хүлээн зөвшөөрөх, хэмжээ хязгаар нь тодорхойгүйгээс үүнд ямар ч зүйлийг хамааруулан ойлгож хэрэглэх нь түгээмэл байх магадлалтай. Өөрөөр хэлбэл сан нь үнэт цаас, хувьцаа бонд гэх мэтийг худалдан авч хөрөнгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх боломжтой эсэх нөхцөл байдлыг хуулиар тодорхойлоогүй бөгөөд хэрэв худалдан авч эх үүсвэр бүрдүүлсэн тохиолдолд энэ нь хууль зөрчсөнд тооцогдох эсэх нь эргэлзээтэй. Мөн хөрөнгийн зарцуулалт дээр бусад арга хэмжээ гэсэн зохицуулалт орж байгаа нь ямар ч арга хэмжээг санхүүжүүлэх боломжийг бий болгож байгаа юм. Иймээс дээрх ойлгомжгүй нөхцөл байдал бий болгоод байгаа “Бусад” гэсэн нэр томъёоноос аль болох татгалзаж боломжит хувилбаруудыг хуульчлах нь зүйтэй гэж үзэж байна.

Засгийн газрын тусгай сангийн хууль нь Засгийн газрын тусгай сангийн төрлийг тогтоож, эдгээр санг бүрдүүлэх, зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд харин уг хуулиар тусгай санд ажиллаж байгаа ажилтны эрх зүйн байдлыг тодорхойлоогүй байгаа юм. Эдгээр сангуудад ажиллаж байгаа ажилтнууд Төрийн албаны тухай хуульд заагдсан төрийн албан хаагчдын ангилалын алинд нь Төрийн тусгай санд ажиллаж байгаа ажилтнууд хамаарч байгаа, эдгээр ажилтнууд төрийн албан хаагчид хамаарах эсэх, эсхүл Хөдөлмөрийн хуулийн дагуу зохицуулагдах эсэх зэрэг чухам ямар хуулиар эдгээр албан хаагчдын харилцаа зохицуулагдах нь тодорхойгүй байгаагаас ажилчдад олгох хангамж, нөхөн олговор, тэтгэвэр тэтгэмж, цалингын хэмжээ зэрэг нөхцөл байдал өнөөг хүртэл тодорхойгүй байна. Одоогийн байдлаар Хөдөлмөрийн хуулийн дагуу гэрээ байгуулж ажиллаж байгаа ч цаашид энэхүү харилцааг зохицуулах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна. Ажилчдыг шинээр авах шалгаруулах зэрэг ямар нэгэн дээр зохицуулалт байдаггүй.

Цэвэр агаарын сантай холбогдуулан ямар нэгэн журмыг Засгийн газар болон холбогдох эрх бүхий байгууллага батлах зохицуулалт хуульд байхгүй байна.

**Санал:** Уг сангийн хувьд Засгийн газрын тусгай сангын хуульд заасан журмын дагуу хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх “Бусад орлого” гэснийг тодруулж тодорхойлох, захиран зарцуулах үйл ажиллагаа дээр тусгайлан журам батлах шаардлага байгаа эсэхийг судалж хэрэв шаардлагатай бол тусгайлан журам батлах эрх зүйн зохицуулалтыг оруулах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна.

## 6. Холбогдох хуулиар батлагдах эрх зүйн актууд батлагдсан эсэх

Энэхүү хэсэгт Агаарын тухай багц хуулиудад доорхи эрх зүйн актуудыг батлан гаргах эрх олгосон хуулийн зүйл, заалтыг түүвэрлэн гаргав.

Эрх зүйн актын хувьд батлагдах ёстой эрх зүйн актууд батлагдахгүй байх, эрх олгоогүй байхад эрх зүйн актыг батлах, хуулиас давсан зохицуулалт хийх, хуультай зөрчилдөх гэх мэт олон тооны зөрчилтэй асуудлууд гардаг учир энэ тайлангийн хүрээнд зөвхөн хуулийн дагуу батлагдах ёстой эрх зүйн актууд батлагдсан эсэхэд түүвэр хийлээ.

Хуулийн дагуу батлагдах ёстой эрх зүйн актууд батлагдахгүй байх нь нэг төрлийн хуулийн зөрчил бөгөөд хуулийн хэрэгжилтэд ч мөн адил сөргөөр нөлөөлдөг.

Д/д	Агаарын тухай	Эрх зүйн акт батлагдсан эсэх
1.	<p><b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</b> 3.1.6. “аюултай бохирдуулах бодис” гэж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад орсон бохирдуулах бодисыг.</p> <p><b>5 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулгын бүрэн эрх</b> 5.1.9. аюултай бохирдуулах бодисын жагсаалтыг батлах.</p>	Батлагдаагүй
2.	<p><b>3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</b> 3.1.16. “физикийн сөрөг нөлөөллийн стандарт” гэж физикийн нөлөөллийн хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх хүлцэх хэм хэмжээг стандартын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсныг.</p>	Батлагдаагүй
3.	<p><b>5 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</b> 5 дугаар зүйлийн “5.1.4. агаарыг хамгаалах талаархи энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан агаарын чанарын мэргэжлийн албаны болон ажлын энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан Уур амьсгалын өөрчлөлтийн албаны дүрмийг баталж, үйл ажиллагааг удирдлагаар хангах”.</p>	<p>БО-ны яамны сайдын тушаал 1996 оны 07 дугаар сарын 05 №98 Журам батлах тухай</p> <p>Уур амьсгалын өөрчлөлтийн зохицуулах албыг БОАЖС-ын 2011 оны 2 сарын 1-ний А-23 тоот Тушаалаар БОАЖЯ-ны дэргэд байгуулан ажиллуулж эхлээд байна.</p>
4.	<p><b>4 дүгээр зүйл. Засгийн газрын бүрэн эрх</b> 4.1. Засгийн газар хүрээлэн байгаа агаар /цаашид “агаар” гэх/-ыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 4.1.1. агаарыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөрийг батлах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах.</p>	<p>УИХ-ын тогтоол 2011-01-06 Дугаар 02 Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр батлах тухай</p>
5.	<p><b>5 дугаар зүйл. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх</b> 5.1.5. агаарын чанарын хяналт-шинжилгээний ажлыг зохион байгуулан хяналт-шинжилгээний арга зүйг баталж, мэргэжлийн удирдлагаар хангах.</p>	Батлагдаагүй
6.	<p><b>8 дугаар зүйл. Агаарын чанарын мэргэжлийн алба</b> 8.3. Мэргэжлийн албаны орон нутаг дахь салбар нь төрийн захиргааны төв байгууллагаас баталсан дүрмийн дагуу Засаг даргын удирдлага дор ажиллана.</p>	Батлагдаагүй
7.	<b>10 дугаар зүйл. Агаарын чанарын тухай</b>	Сайдын тушаал

	<b>мэдээлэл</b> 10.5.Агаарын чанарын мэдээ гаргах журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.	2010 оны дугаар сарын №98 Журам батлах тухай /шинээр батлагдсан/
<b>8.</b>	<b>11 дүгээр зүйл. Агаарыг хамгаалахтай холбогдолтой хэм хэмжээ</b>  11.1.Агаар бохирдуулах бодисын болон агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх хэм хэмжээг тогтоох агаарын чанарын стандарт, физикийн сөрөг нөлөөллийн стандарт, хог хаягдлыг зориулалтын байгууламжид шатаах, устгах үйл ажиллагааны улмаас агаарт ялгарах хаягдлын стандартыг төрийн захиргааны төв байгууллага боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулна.	Агаар мандал. Агаарын бохирдуулах бодисыг тодорхойлох аргад тавих ерөнхий шаардлага. MNS 3113 : 1981  Агаарын чанарын мэдээ гаргах журам”, “Агаар бохирдуулах эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”, “Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох журам”, “Агаарын чанарын мэдээ гаргах журам”, “Агаарын чанарыг индексээр үнэлэх, мэдээлэх ерөнхий журам”, “Агаарын чанарын индексийн мэдээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх аргачлал”
<b>9.</b>	11.2.1.Бүх төрлийн зуухнаас агаарт гаргах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийн хаягдлын стандартыг түлш, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран.	1. Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үед агаар мандалд хаях утааны найрлага дахь бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга. MNS-5919:2008  2. Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5457: 2005
<b>10.</b>	11.2.2.агаарын бохирдлын хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэмжилтийн аргачлалыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран.	Бензин хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS5013:2009  Дизель хөдөлгүүртэй автомашин-Утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS5014:2009
<b>11.</b>	11.2.3.нүүрсийг гүн боловсруулах замаар гаргах шинэ түлшний стандартыг түлшний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран.	Шахмал түлш. Техникийн ерөнхий шаардлага" MNS 5679:2011
<b>12.</b>	11.2.4.автобензин, дизель, шингэрүүлсэн шатдаг хий зэрэг түлш, шатахууны стандартыг автотээврийн болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран.	Шингэрүүлсэн нефтийн хий - Ахуйн хэрэглээний түлш - Техникийн шаардлага MNS 5083 : 2001  Дизелийн түлш. Техникийн шаардлага. MNS 0216 : 2006

		Дотоод шаталтат хөдөлгүүрийн түлш. Автобензин. Техникийн шаардлага. MNS 217-2006
13.	<b>12 дугаар зүйл. Агаарын чанарыг сайжруулах бүс</b> 12.3.Агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг заасан тухайн бүсэд мөрдөх журмыг төрийн захиргааны төв байгууллага нутгийн захиргааны байгууллагатай хамтран батална.	НИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол 2011 оны 9 дүгээр сарын 7 Дугаар 131 Журам батлах тухай
14.	<b>13 дугаар зүйл. Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглах зөвшөөрөл</b> 13.3.Энэ хуулийн 13.2-т заасан бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.	Сайдын тушаал 1996 оны 07 дугаар сарын 05 №98 Журам батлах тухай
15.	<b>16 дугаар зүйл. Барилга байгууламж барих, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд агаарыг хамгаалах талаар тавих шаардлага</b> 16.4.Суурин газрын агаарыг хамгаалах зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бүс тогтоож хүн амын суурьшлын бүсээс зааглах бөгөөд уг бүсийн хэмжээг үйлдвэрлэл, үйлчилгээний салбар, төрөл бүрээр тогтоосон жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Батлагдаагүй
16.	<b>20 дугаар зүйл. Озоны үе давхаргыг хамгаалах</b> 20.1.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.	ЗГ-ын тогтоол 1999 оны 6 дугаар сарын 23-нд батлагдсан. №104 Журам батлах тухай
17.	<b>20 дугаар зүйл.Озоны үе давхаргыг хамгаалах</b> 20.5.Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмж болон хураагдсан бодисыг устгах, зайлуулах, нөөцөлж хадгалах журмыг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.	Батлагдаагүй
18.	<b>21 дүгээр зүйл.Агаар бохирдуулах бодисын хаягдал, физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл</b> 21.2.Улсын нэгдсэн тоо бүртгэл, агаар бохирдуулах бодисын хаягдал, агаарт үзүүлэх физикийн сөрөг нөлөөлөл, тэдгээрийн эх үүсвэрийн улсын тооллогыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журмын дагуу мэргэжлийн алба гүйцэтгэнэ.	Батлагдаагүй
19.	<b>25 дугаар зүйл.Цэвэр агаарын сан</b> 25.5.Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон	ЗГ-ын тогтоол Журам батлах тухай 2010 оны 10 дугаар сарын 20

	тооны бус Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.	№273
<b>д/д</b>	<b>Агаарын бохирдлын төлбөрийн тухай</b>	<b>Эрх зүйн акт батлагдсан эсэх</b>
1.	<b>4 дүгээр зүйл.Агаарын бохирдлын төлбөр төлөгч, түүнийг бүртгэх</b> 4.5.Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөр авах журам, төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар тогтооно.	Засгийн газрын тогтоол Төлбөрийн хувь, хэмжээ тогтоох тухай №92 2011.03.22
2.	<b>5 дугаар зүйл.Агаарын бохирдлын төлбөр ногдох зүйл</b> 5.2.Төлбөр ногдуулах органик уусгагчийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Засгийн газрын тогтоол 2010 оны 173 тоот Агаарын бохирдлын төлбөрийн хэмжээ
3.	<b>5 дугаар зүйл.Агаарын бохирдлын төлбөр ногдох зүйл</b> 5.3.Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн нэгж километр зайд явахад ялгарах нүүрсхүчлийн хийн хэмжээгээр нь бүлэглэх ангиллыг суудлын автомашины хөдөлгүүрийн багтаамж, автобус, ачааны автомашины даацаас хамааруулан тогтоох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.	БОАЖЯ, ЗТБХЯ хамтарсан тушаал 2011 оны 3 дугаар сарын 7 №А-63/67 Журам батлах тухай
4.	<b>5 дугаар зүйл.Агаарын бохирдлын төлбөр ногдох зүйл</b> 5.4.Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах бохирдуулах бодисын жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.	Засгийн газрын тогтоол Төлбөрийн хувь, хэмжээ тогтоох тухай №92 2011.03.22
5.	<b>7 дугаар зүйл.Төлбөрийн хувь, хэмжээ</b> 7.1.Олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.	ЗГ-ын тогтоол Журам батлах тухай 2010 оны 10 дугаар сарын 20 №273
6.	<b>7 дугаар зүйл.Төлбөрийн хувь, хэмжээ</b> 7.2.Үйлдвэрлэсэн болон импортолсон органик уусгагчийн төлбөрийн хувь, хэмжээг органик уусгагчийн килограмм тутамд 10-30 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.	ЗГ-ын тогтоол Журам батлах тухай 2010 оны 10 дугаар сарын 20 №273
7.	<b>7 дугаар зүйл.Төлбөрийн хувь, хэмжээ</b> 7.4.Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдлын бохирдуулах бодисын төлбөрийн хувь, хэмжээг килограмм тутамд 1-10 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.	Засгийн газрын тогтоол Төлбөрийн хувь, хэмжээ тогтоох тухай №92 2011 оны 3 дугаар сарын 22
9.	<b>8 дугаар зүйл.Төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх</b> 8.6.Энэ хуулийн 8.5-д заасан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт болон төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх журмыг Засгийн газар батална.	Батлагдаагүй
10.	9 дүгээр зүйл.Төлбөр төлөх, тайлагнах.	2011 оны 06 дугаар сарын 13

	9.6.Төлбөрийн тайлангийн маягтын загварыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.	Татварын Ерөнхий газрын даргын 336 тоот тушаал
Д/д	<b>Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай</b>	<b>Эрх зүйн акт батлагдсан эсэх</b>
1.	<b>5 дугаар зүйл.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох</b> 5.1.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийслэлийн Засаг даргатай хамтран <b>тогтоож</b> , энэ талаар нийтэд мэдээлнэ.	Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр нар хамтран “Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүс”
2.	<b>9 дүгээр зүйл.Ерөнхийлөгчийн бүрэн эрх</b> 9.2.Энэ хуулийн 9.1.1-д заасан Үндэсний хорооны бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар батална.	<b>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2011 оны ... дугаар зарлигийн 2 дугаар хавсралт</b> Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний хорооны ажиллах журам
3.	<b>10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх</b> 10.1.Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 10.1.4.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан нөхцөл, шалгуурын аль нэгийг хангасан айл өрхөд цахилгаан, эрчим хүчний үнийг 50 хувиар бууруулах урамшууллын арга хэмжээг авч, зөрүүг улсын төсвөөс санхүүжүүлэх; 10.1.7.агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох; 10.1.10.энэ хуулийн 10.1.4, 10.1.7-д заасан урамшууллыг олгох журам батлах.	<b>Засгийн газрын 2011 оны дугаар тогтоолын 2 дугаар хавсралт</b> Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам <b>Засгийн газрын 2011 оны дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт</b> Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журам
4.	<b>10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх</b> 10.1.8.нийслэлийн хүн амын төвлөрлийг сааруулах зорилгоор хот орчмын суурьшлын бүс, алслагдсан дүүргийг хурдны авто зам, цахилгаан төмөр зам, гүүр, эрчим хүч, инженерийн шугам сүлжээ бүхий дэд бүтцийг бий болгох замаар хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	УИХ-ын тогтоол Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр 2010-06-15 Дугаар 36
5.	<b>10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх</b> 10.1.Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 10.1.11.Гэр болон барилга, байгууламжийн дулаалгын нэгдсэн стандарт боловсруулан батлуулж, мөрдүүлэх.	Батлагдаагүй

## 7. Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөөн дэх зөвлөмжийн хэрэгжилт

Цэвэр агаар санаачлага I төслийн үр дүнд Үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө батлагдсан. Энэхүү төлөвлөгөөнд Агаарын тухай хуультай холбогдуулан доорхи хууль, эрх зүйн өөрчлөлт хийх зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- *Улаанбаатарын зарим дүүрэг хороололд хэрэглэж байгаатай адил түүхий нүүрсийг зарж борлуулахыг эрх зүйн хүрээнд онцгойлон хориглох.*

Дээрхи зөвлөмжийн дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтанд Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс болон агаар бохирдуулах бусад хаягдал зүйлс шатаахыг хориглосон.

Гэвч хямд төсөр орлуулагч түлшээр тогтвортой хангаж, түгээх ажиллагааг дэмжих, түлш орлуулан солих хөтөлбөрийг нэвтрүүлж эхлэхтэй зэрэгцэн хэрэглэгчдэд аль болох нэмэлт зардал чирэгдэл учруулахгүй байх, 3) хөтөлбөрийн шаардлагыг хянаж, хэрэгжилтийг хангаж ажиллах, 4) тухайн асуудал болон нүүрсний хэрэглээг хориглосноор шийдвэрлэх арга



замын талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг дээшлүүлэх зэргийг зэрэг хангаж байж уг хориг хэрэгжих үндэслэлтэй гэдгийг бусад орны туршлагын дагуу зөвлөсөн байна.

- *Түлш орлуулан солиход чиглэгдсэн эрх зүйн орчин нь бүхий л оролцогч талуудын эрх болон үүргийг тодорхой, энгийн байдлаар тогтоож, хууль зөрчсөн тохиолдолд ногдуулах хариуцлага шийтгэл, үр дагаврыг тодорхой бүрдүүлсэн байх ёстой.*

Дээрхи хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг Агаарын хуульд тусгаагүй байна. Мөн Агаарын тухай холбогдох хуульд оролцогч талуудын эрх болон үүргийг хэрхэн оновчтой тодорхойлсныг тухай бүрд нь авч үзсэн ба хуулийн тайлангаас үзэж болно.

- *Үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн үзэл баримтлал нь УИХ-аас батлан гаргах нэг гол цөм хууль (Цэвэр түлшний тухай хууль гэх мэт, энгийнээр цаашид хууль гэх) болон үүнд холбогдох хууль тогтоомжоос бүрдэнэ. Үүнд:*
  - *Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн төсөлд оруулах нэмэлт өөрчлөлтийг дор дурдсан Агаарын бохирдлын төлбөрийн санал зөвлөмжид уялдуулж тусгах.*
  - *Цэвэр агаарын сангийн тухай хууль тогтоомжийг бүтэц зохион байгуулалтын бүдүүвч болон тогтоол шийдвэрийн хамт.*
  - *Хотын одоогийн бүсчлэлийн талаарх тогтоол шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах*
  - *Монгол улсын Стандарт, хэмжил зүйн төвөөс тусгайлан тусад нь гаргах цэвэр түлшний стандартын тухай журам.*
  - *Зуухны хорт утаа ялгаруулалтын стандарт, холбогдох дэлгэрэнгүй дүрэм журам.*

Дээрхи бүх стандартууд батлагдсан байна.

- *Урамшуулал, төлбөрийн чадварыг дэмжих татаас*

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд урамшуулал, татаасыг хэрхэн олгох, хэнд олгох талаар тодорхой зөвлөгөө өгсөн бөгөөд энэхүү зөвлөмжийн дагуу 2011 онд Засгийн Газар Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, цахилгаан эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох журам, Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний үнийн урамшуулал олгох журмыг тус тус батлан гаргасан байна.

- *Агаар бохирдуулсны нөхөн төлбөрийн өгөөж- Хэрэв зүй зохистой ногдуулж чадвал агаар бохирдуулсны нөхөн төлбөр нь ашиг орлогыг нэмэгдүүлэх, агаарын бохирдлыг бууруулах хоёр талын ач холбогдолтой. Агаар бохирдуулсны нөхөн төлбөрийн тогтолцоог бүрдүүлэхдээ хууль тогтоомжийн зохицуулалтаас гадна бусад хүчин зүйлсийг тусгах шаардлагатай бөгөөд ингэснээр иргэд, компаниуд бохирдуулагч түлш хэрэглэхээс татгалзаж, цэвэр түлш хэрэглэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийж, хөрөнгө мөнгө зарцуулах урамшууллын хөшүүрэг бүрдэх болно. Агаар бохирдуулсны нөхөн төлбөр хураалтаас босгосон ашиг орлогыг ерөнхий зорилгоор ашиглах эсхүл байгаль орчны тусгай хөтөлбөр санхүүжүүлэхэд тодорхой заасан хувийг ашиглах боломжтой.*

Дээрхи агаар бохирдуулсны төлбөрийн хэмжээг Агаарын бохирдлын тухай хуульд тусгасан ба зөвлөмжийн агуулга тус хуульд тусгагдсан байна. Мөн ногдуулах төлбөрийн

хэмжээ нь ч бас зөвлөмжид дурдсан хэмжээтэй нийцэж байна. Харин Агаар бохирдуулсны нөхөн төлбөрийн хэмжээг хэрхэн тооцож авах тухай хуульд тусгагдаагүй байна.

- *Түүхий нүүрсний хориглолтын зөрчилд ноогдуулах торгууль-Улаанбаатар хотын хориг таавьсан дүүрэг, газруудад түүхий нүүрс зарсан нүүрсний үйлдвэрлэгч буюу борлуулагчдад санхүүгийн торгууль шийтгэл ногдуулах нөхцөлтэйгээр түүхий нүүрсийг хоригийг бодитой хэрэжүүлэхэд чиглэсэн агаарын тухай хууль эрх зүйн орчин бүрдүүлбэл зохино. Гэвч анхаарвал зохих асуудал бол цэвэр түлшний нийлүүлэлт зах зээлд хүртээмжтэй хангагдсан нөхцөлд иймэрхүү хатуу чанд арга хэмжээг хууль сахиулах хүрээнд авч хэрэжүүлэх боломжтойг тэмдэглэх нь зүйтэй. Гэвч цэвэр түлшний хангалт оргил үед хүрсэн байсан ч, ийм торгууль шийтгэлээс олох орлого боломжийн бага түвшинд байх тусмаа оновчтой.*

Дээрхи зөвлөмжид дурдсан хязгаарлалтын бүсэд түүхий нүүрс зарсан тохиолдолд ногдуулах шийтгэлийг хуульд тусгаагүй ба энэ нь цэвэр түлшний нийлүүлэлттэй холбоотой байж болох юм.

- *Цэвэр түлшний тухай хуулийн агуулга ба зарчим-Цэвэр түлшний тухай хууль нь цэвэр агаарын тухай институцийн орчин болон холбогдох үүрэг хариуцлагыг албан ёсоор тогтоох эрх зүйн ихэнх шаардлагуудыг тусгасан байвал зохино. Цэвэр түлшний тухай хуулиар түүхий нүүрсийг хязгаарлах бүс нутгийг тогтоох ба энэ бүс нутгийг хотын захиргаанаас тогтооно. Гэхдээ энэхүү бүс нутгийг тогтоохдоо цэвэр түлшний нийлүүлэлт хангалттай, тогтвортой байх нөхцлийг анхаарах шаардлагатай.*

Цэвэр түлшний тухай хуулийг одоогоор батлан гараагүй бөгөөд харин хязгаарлалтын бүсийг БОАЖЯ болон нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор хамтран баталсан.

- *Цэвэр түлшний стандарт- Гэвч одоогоор хагас коксжсон нүүрс болон бусад цэвэр түлшний стандарт хараахан байхгүй. Стандарт тогтоох тухайд Дублин хотод ашигласантай төстэй стандартын загвар (формат)-ыг бид анхлан авч үзсэн бөгөөд энэ нь (i) утааны ялгаруулалт, (ii) илчлэгийн дээд хэмжээ, (iii) дэгдэмхий чанарт хязгаар тогтоодог. Иймд Цэвэр түлшний тухай хуульд түлшний гол стандарт тогтоож, мөрдөх шаардлагыг тусгахыг зөвлөж байна.*

Одоогоор MNS 5679 : 2011 Шахмал түлш, техникийн шаардлага, MNS 5413 : 2011 Түлшний мод Техникийн шаардлага 2 стандарт батлагдсан гарсан байна.

- *Зуухны стандартууд ба цэвэр зуухны гэрчилгээ олгох-Зуухны стандартын хувьд сүүлийн үеийн боловсронгуй зуухны загварыг уялдуулж тусгасан байхаар шинэчилж өөрчлөөгүй. Эрх зүйн орчинтой холбоотой зорилгоор авч үзвэл, цэвэр түлшний стандартын дэлгэрэнгүй шалгуур үзүүлэлтүүдийг хуульчлах шаардлагагүй, учир нь хуульд тэдгээрийг эрх зүйн орчинд нийцүүлж бүрдүүлэх, мөн тус улсад одоогоор хэрэжиж буй бусад стандартуудын адил сайн дурын шинжтэй бус эрх зүйн талаас бодитой хэрэгжихүйц байхаар ёстой. Халаалтын хэрэгслийн стандартын дэлгэрэнгүй шаардлага, үзүүлэлтийг шилдэг туршлагад суурилсан түлшний стандартын хамт зэрэгцэн боловсруулбал зохино.*

MNS 5216-1: 2011 Ахуйн хэрэглээний зуух, техникийн ерөнхий шаардлага стандарт батлагдсан байна.

- *Цэвэр түлшний гэрчилгээний тухай заалт- Цэвэр түлшний стандартыг доор тодорхойлсон туршилтын шинжилгээнд суурилан тогтооно. Стандарт хангаж буй түлшний бүтээгдэхүүнийг Засгийн газрын албан ёсны хангалт шалгалт бүхий гэрчилгээ олгох үйл явцын дагуу зөвшөөрөл олгоно. Цэвэр түлшний тухай хуульд*

тэрхүү гэрчилгээг олгох, хэн батламж олгох үндэслэлийг хэрхэн нотолж баталгаажуулах, зөрчил гаргасан тохиолдолд ямар хариуцлага шийтгэл ногдуулахыг тодорхой заавал зохино. Ийм гэрчилгээ олгох арга хэмжээг дэмжих үүднээс цэвэр түлшний бүтээгдэхүүнд гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага нь тогтсон лого бүхий тэмдэгжүүлэх системийг бидний зүгээс зөвлөж байна.

Цэвэр түлшний тухай хууль батлагдаагүй.

- Чанарын тэмдэгжүүлэлт-Засгийн газрын буюу холбогдох эрх бүхий байгууллагад албан ёсоор бүртгүүлсэн, хуулиар тогтоосон стандартын шаардлага хангасан цэвэр түлшинд гэрчилгээ олгох байгууллагыг онцолж таних зурган тэмдэг буюу лого хэрэглэхийг зөвлөж болгож байна. Ийм тэмдэг буюу лого нь гэрчилгээ олгох тухайн байгууллагын бүртгэлийн дугаарыг тусгахаас гадна цэвэр түлшний гэрчилгээ олгох үйл явцын салшгүй нэг хэсэг болох үүднээс эрх бүхий байгууллагаас гэрчилгээ авсан бүтээгдэхүүний тээвэрлэх сав баглаа болгон дээр тавьж наасан байвал зохино. Зохицуулагч байгууллагын буюу хууль хяналтын ажилтнууд цэвэр түлшний тээвэрлэж түгээх эрх бүхий гэрчилгээт байгууллагыг хялбар таньж илрүүлэх боломж бүрдэнэ.

Цэвэр түлшний тухай хууль батлагдаагүй.

- Хууль сахиулах механизм- Хуульчилсан хоригийн амжилттай хэрэгжүүлэхийн тулд тус хуулийн хэрэгжилтийг хангах механизм бүрдүүлэх, мөн түүний талаар хориг тавьсан хуульд тодорхой заалтууд тусгаж оруулах явдал юм. Бусад улс орнуудад хууль хэрэгжүүлэх харилцан адилгүй аргууд хэрэглэх бөгөөд тэдгээр заалтууд нь нийгэм, эдийн засгийн чиглэлийн эрх зүйн болон соёлын хэм хэмжээ, нөхцөл байдлыг тусгасан байдаг. Их Британи улсад хууль сахиулах механизм нь хориглосон түлш хэрэглэгчдийн эсрэг чиглэсэн байхад Ирланд улсад хориглосон түлшийг зарж борлуулж, нийлүүлсэн этгээдийн эсрэг чиглэгддэг. Улаанбаатарт түгээмэл орших өвөрмөц нөхцөл байдлууд болон хууль сахиулах үйл явцаас үүдэн өвлийн хатуу ширүүн хүйтний улиралд айл өрхүүд гэрээ дулаацуулж чадахгүйд хүргэж болзошгүй үр дагаврыг харгалзан, хууль сахиулах арга хэмжээ нь хэрэглэгчдийн эсрэг байх ёсгүйг бидний зүгээс зөвлөж байна. Харин Их Британи болон Европын хууль тогтоомжид хэрэглэгчдийн цэвэр түлшний хууль сахиулах механизмтай адил төстэй, үйлдвэрлэгчийн хариуцлага болон халамж анхаарал тавих механизмуудыг хослуулсан хэлбэрийг зөвлөж болгоно. Иймд хууль сахиулах механизм үйлдвэрлэгчдэд голлон чиглэгдэх бөгөөд борлуулалт нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын гол үүрэг хууль тогтоомжийг биелүүлснээр үйлдвэрлэгчид цэвэр түлшний талаар өндөр түвшинд хяналт тавьж, зохих ёсны гэрчилгээ авч, тэмдэгжүүлэгдсэн эсэхийг нягтлах боломж бүрдэнэ. Түүнчлэн, үйлдвэрлэгч түлшний талаар эдийн засгийн гол сонирхолтой тал байх болно. Иймд хэрэв гэрчилгээ олгогч эрх бүхий байгууллага, борлуулагчид, нийлүүлэгчид санал болгож буй хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагыг биелүүлээгүй тохиолдолд цэвэр түлшний хууль сахиулах механизм нь тэдний эсрэг арга хэмжээ авах боломжийг бүрдүүлсэн байвал зохино. “Үйлдвэрэгч” нь цэвэр түлшний нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч гол тал байх бөгөөд Монгол улсын нутаг дэвсгэр дээр цэвэр түлш үйлдвэрлэхээс гадна гаднаас импортолж болно.

Агаарын тухай хуулийн 6 хариуцлага хүлээх тухай заалтын 4 нь иргэнд, 1 нь төрийн албан хаагчид, 1 нь бусад этгээдэд хамааралтай зохицуулалт болсон байна. Өөрөөр хэлбэл хэрэглэгчдийн эсрэг чиглэсэн зөвлөмжид дурдсанаас өөр агуулгатай зохицуулалт болсон байна.

- Хяналт үнэлгээний тухай заалт- Цэвэр түлшний хэрэглээнд шилжихэд гарах амжилтыг хэмжиж болохуйц байх ёстой. Үүнд агаарын хяналт үнэлгээний найдвартай суурь мэдээлэл, хяналт үнэлгээний нарийн сүлжээ (нэтворк) шаардлагатай бөгөөд Цэвэр агаарын тухай хуульд тусгаж заасан байвал зохино. Өмнө дурдсанчлан Цэвэр агаарын тухай хуульд хэт дэлгэрэнгүй заалт оруулах шаардлагагүй, харин үүнд

агаарын чанарыг хянах шаардлагатай тухай болон Хотын удирдлага болон Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам нь хяналт үнэлгээний журамд тодорхой дэлгэрэнгүй заалтууд тусгах эрх мэдэлтэй тухай заасан зүйл байхад хангалттай.

Монгол улсын агаарын чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээнд Монгол орны хот суурин газрын агаар, цацрагийн түвшний өөрчлөлтийг байнга шинжлэн судлах, агаар бохирдуулах эх үүсвэрүүдэд хяналт тавих байгаль орчны шинжилгээний 12 лаборатори, агаарын чанарын хяналтын 36 харуул, байгалийн цацрагийн фони хэмжилтийн 35 цэг ажиллаж байна. Үүнээс Улаанбаатар хотод агаарын чанарын сорьц авах 9 суурин харуул (УБ 1-8, Багануур харуул), орон нутагт 20 аймгийн төвд 22, сумын төвд 2 суурин харуул үйл ажиллагаа явуулж байна.

- Хоригоос чөлөөлөгдөх-Урьдчилсан үндсэн туршилтад тулгуурлан, түүхий нүүрсийг үр ашигтай түлэх боломжтой зуухны загвар хийц, үйлдвэрлэлийг хамруулах боломж нөхцөл байгаа төдийгүй энэ нь хүлэмжийн ялгарлыг хүлээн зөвшөөрөгдөхүйц бага түвшинд хүргэхэд эерэг нөлөө үзүүлэх боломжтой гэж үзэв. Ийм зуухыг боломжит тоо хэмжээгээр үйлдвэрлэж болох ч тус зууханд түлэх түүхий нүүрсийг хоригоос чөлөөлөхөд хүрч болзошгүй. Иймд халаалт, хоол унд бэлтгэхэд түүхий нүүрс ашиглахыг хуульчлан хориглохыг зөвлөмж болгох хэдий ч тус заалтад хүлэмжийн ялгарлыг бууруулах чадвартай зуухны технологи нэвтрүүлэх зэргээр хүлэмжийн ялгарлыг зөвшөөрөгдөхүйц түвшинд бууруулах боломжтой нөхцөлд түүхий нүүрсийг хоригоос чөлөөлөх тухай тусгана. Түлшний тухай хууль нь үндсэн гол зарчмуудыг бүрдүүлэх бөгөөд цаашид батлагдах хууль тогтоомжид нарийн тодорхой зааж тусгана. Эдгээр үндсэн зарчмууд нь хүлэмжийн ялгарал, чанар, аюулгүй байдал, түлш ба зуухны бүтээгдэхүүнүүдийг хамруулсан халаалтын системийн гүйцэтгэлийн стандартууд бүрдүүлэх эрх зүйн үндсийг тодорхойлж өгнө.

Дээрхи бүх зохицуулалтыг Цэвэр түлшний тухай хуульд тусгах боломжтой. Сайжруулсан зуух ашигласан тохиолдолд урамшуулал олгох тухай заалт Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд тусгагдсан байна.

## 8. Хавсралтууд

### 8.1. Хавсралт 1. Холбогдох хуулиуд

д/д	Холбогдох хуулиуд	Батлагдсан он, сар, өдөр
1	МУ-ын Үндсэн хууль	1992-01-13
2	Байгаль орчныг хамгаалах тухай	1995-03-30
3	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай	1998-01-22
4	Агаарын бохирдлын төлбөрийн тухай	2010-06-24
5	Татварын ерөнхий	2008-05-20
6	Ариун цэврийн тухай	1998- 05-07
7	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай	2011- 02-10
8	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай	2001-02-01
9	Гамшгаас хамгаалах тухай	2003-06-20
10	Газрын тухай хууль	2002-06-07
11	Монгол Улсын Их Хурлын тухай	2006 -01-26

12	Статистикийн тухай	1997-06-05
13	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай	1997-11-13
14	Төрийн хяналт шалгалтын утхай хууль	2003-01-03
15	Эрүүгийн хууль	2002-01-03
16	Эрчим хүчний тухай хууль	2001-02-01
17	Химийн хорт болон аюултай бодисын тухай	2006-05-25
18	Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай	2000-11-03

## 8.2. Хавсралт 2. Улсын Их Хурлын тогтоол

д/д	Холбогдох тогтоолууд	Тогтоолын дугаар	Батлагдсан он, сар, өдөр
1	Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай	03	2005.01.13
2	Төрөөс экологийн талаар баримтлах бодлого батлах тухай	106	1997.12.26
3	Үндэсний хөтөлбөр батлах тухай	29	1998.04.29
4	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр батлах тухай	32	2005.06.09
5	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай	67	2005.11.17
6	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	11	2011.02.10
7	“Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр батлах тухай	Дугаар 36	2010. 06. 25

### 8.3. Хавсралт 3. Засгийн газрын тогтоол

д/д	Холбогдох тогтоолууд	Тогтоолын дугаар	Батлагдсан он, сар, өдөр
1	40000 орон сууц хөтөлбөр батлах тухай	№144	2005.06.27
2	Агаарын бохирдлыг бууруулах талаар ойрын хугацаанд авах зарим арга хэмжээний тухай	№14	2008.01.16
3	Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай	№56	2006.03.28
4	Байгаль орчны хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай	№151	1995.08.25
5	Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг батлах тухай	№161	2000.10.23
6	Нийслэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай	№70	2007.03.20
7	Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр батлах тухай	№245	2005.12.14
8	Төлөвлөгөө батлах тухай	№273	2001.12.12
9	Төлөвлөгөө батлах тухай	№6	1997.01.02
10	Утаа багатай түлш, хэмнэлттэй зуухны үйлдвэрлэлийг дэмжих тухай	№70	2001.03.28
11	Хөтөлбөр батлах тухай /Байгалийн гамшгийн аюулыг бууруулах үндэсний хөтөлбөр/	№25	1999.02.10
12	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай / Ус, цаг уур, орчны хяналт-шинжилгээний салбарыг 2015 он	№182	2002.09.0.9

	хүртэлх хугацаанд хөгжүүлэх хөтөлбөр /		
13	Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай /Агаарыг хамгаалах хөтөлбөр/	№82	1999.05.25
14	Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөө батлах тухай	№140	2002.07.04

#### 8.4. Хавсралт 4. Олон Улсын гэрээ

д/д	Холбогдох гэрээнүүд	Батлагдсан
1	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенц	2005.06.27
2	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын суурь конвенцийн Киотогийн протокол	2008.01.16
3	Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэхэд хяналт тавих тухай Базелийн конвенци	1996
4	Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенци	2000
5	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци	2003

**8.5. Хавсралт 5. Сайдын тушаал**

д/д	Холбогдох тушаалууд	Тушаалын дугаар	Батлагдсан он, сар, өдөр
1	БОАЖЯ “Жагсаалт, журам батлах тухай”	№126/171	2003.07.01
2	БОАЖЯ “Журам батлах тухай”	№98	1996.07.05
3	БОАЖЯ “Заавар батлах тухай”	№45	2000.03.29



## 8.6. Хавсралт 6. Агаарын тухай хуультай холбогдох Монгол Улсын стандартууд

д/д	Холбогдох стандартууд
1.	MNS 0216 : 2006 Дотоод шаталтат хөдөлгүүрийн түлш дизелийн түлш, Техникийн шаардлага татаж авах
2.	MNS 0296 : 2008 Гэрийн эсгий техникийн шаардлага
3.	MNS 0652 : 1979 Хүрэн, чулуун нүүрс, антрацит ба шатах занар үнслэг тодорхойлох арга.
4.	MNS 0655 : 1979 Хүрэн, чулуун нүүрс, антрацит ба шатах занар чийгийг тодорхойлох арга.
5.	MNS 0669 : 1987 Хатуу түлшийг шатаахад гарах илчлэгийн дээд хэмжээг тодорхойлох, илчлэгийн доод хэмжээг тодорхойлох арга
6.	MNS 0893 : 1980 Хүрэн чулуун нүүрс, антрацит ба шатах занар.үзэгдэх чулуулаг ба жижигэрсэн хэсгийг ширхэгийн агуулгыг тодорхойлох, хяналтын дээжийг турших арга.
7.	-MNS 1744 : 1982 Хатуу түлш шинжлэх үзүүлэлтийн тэмдэглэл, янз бүрийн төлөвтэй түлшний Шинжилгээний үр дүнг шилжүүлэн тооцох томъёо
8.	MNS 2732 : 2001 Хүрэн ба чулуун нүүрс, антрацит, шатах занар Ашиглалтын дээж авах арга
9.	MNS 3217 : 1982 Хатуу түлш нягтыг тодорхойлох арга
10.	MNS 3903 : 1986 Хатуу түлш хүхэр тодорхойлох арга
11.	MNS 3902 : 1986 Хатуу түлш. Үнсний хайлах температурыг тодорхойлох арга.
12.	MNS 4585 :2007 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага
13.	MNS 5013 : 2009 Бензин хөдөлгүүртэй автомашин – утааны найрлага дахь Хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
14.	MNS 5014 : 2009 Дизель хөдөлгүүртэй автомашин – утааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга
15.	MNS 5041 : 2001 100 квт хүртэл чадалтай ус халаах зуух.
16.	MNS 5043 : 2001 0.10 мвт - 3.15 мвт хүртэл чадалтай халаалтын зуух, техникийн ерөнхий шаардлага
17.	MNS 5045 : 2001 Хатуу түлшээр ажилладаг ус халаах зуух, Техникийн шаардлага
18.	MNS 5083 : 2001 Шингэрүүлсэн нүүрсустөрөгчийн хий, Ахуйн хэрэглээний түлш – Техникийн шаардлага
19.	MNS 5087:2001 Ус халаах зуух Нэр томъёо, тодорхойлолт
20.	MNS 5216-1 : 2011 Ахуйн хэрэглээний зуух, техникийн ерөнхий шаардлага
21.	MNS 5413 : 2011 Түлшний мод Техникийн шаардлага
22.	MNS 5457 : 2005 Халаалтын ба гэрийн зуухны яндангаар гарах утааны найрлага дахь агаар бохирдуулагч бодисын хүлцэх дээд хэмжээ ба хэмжих арга
23.	MNS 5568 : 2005 Шингэн түлшээр ажилладаг ахуйн хэрэглээний зуух,Техникийн ерөнхий шаардлага
24.	MNS 5679 : 2011 Шахмал түлш, техникийн шаардлага
25.	MNS 5919 : 2008 Дулааны цахилгаан станц, дулааны станцын уурын ба ус халаах зуухны ашиглалтын үе дагаар мандалд хаях утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, тэдгээрийг хэмжих арга
26.	MNS ISO 562 : 2001 Чулуун нүүрс ба кокс – Дэгдэмхий бодисын гарцыг тодорхойлох
27.	MNS ISO 589 : 2003 Чулуун нүүрс – Нийт чийгийг тодорхойлох
28.	Уурын зуух - Нэр томъёо тодорхойлолт
29.	MNS ISO 1129: 2004 Зуух, уур халаагуур, дулаан солилцуурын ган хоолой хэмжээс, хүлцэх зөрүү, нэгж уртын жин
30.	MNS ISO 1170 : 2001 Нүүрс ба кокс – Янз бүрийн төлөвтэй түлшний шинжилгээний үр дүнг шилжүүлэн тооцоолох
31.	MNS ISO/TS 16528 : 2005 Зуух ба даралтат сав – Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дүрэм, стандартын бүртгэл

## **8.7. Хавсралт 7. Цэвэр Агаарын Сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийн жагсаалт**

1. Үндсэн хууль
2. УИХ-ын тухай хууль
3. Засгийн газрын тухай
4. Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай
5. Засгийн газрын тусгай сангийн тухай
6. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай
7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай
8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
9. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай
10. Нягтлан бодох бүртгэлийн тухай
11. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай
12. Төрийн хяналт, шалгалтын тухай
13. Төрийн аудитын тухай

### 8.8. Хавсралт 8. Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өгөх санал.

Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд 2011 оны 12 сарын 30-нд өргөн мэдүүлсэн бөгөөд уг өргөн мэдүүлсэн төсөлтэй холбогдуулан дараах саналыг бэлтгэв. Энэхүү санал нь уг төсөл, судалгааны үр дүнд бий болсон дүгнэлтэнд тулгуурласан болно.

2010 оны Агаарын тухай хуулийн зөрчил, хийдэлтэй заалтууд	Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/	Санал өгөх хууль зүйн үндэслэл, тайлбар	Төслийн багийн санал
<b>Агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой үндсэн зохицуулалтын талаар:</b>			
<p>Агаарын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7.</p> <p>“Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих үүрэгтэй”</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 7 дугаар зүйлийн 7.1.8.</p> <p>“озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих”</p>	<p>Энэхүү заалтад хэрхэн хяналт тавих арга механизм тодорхойгүй, үе шаттайгаар бууруулах гэдгийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй, салаа утгатай зохицуулалт болсон байна. Өөрөөр хэлбэл: Үе шаттай бууруулна гэдэг нь ямар хугацаанд ямар түвшинд хүргэх зорилт нь тодорхой, биелэгдсэн эсэхийг дүгнэж болохоор байх шаардлагатай. Хуулийн зохицуулалт нь хүрэх үр дүн нь маш тодорхой байх ёстой бөгөөд хийсвэр хүрэх үр дүн нь тодорхойгүй зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх боломжгүй юм. Иймд цаг хугацааны хувьд ямар үеийг хамаарч, озон задалдаг бодисын хэрэглээг хэдэн хувиар бууруулахыг тодорхой болгох шаардлагатай байна.</p>	<p>“Төрийн захиргааны байгууллага озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах хөтөлбөр боловсруулах уг хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих” гэж оруулах,</p>
<p>Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1.3.</p> <p>“Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох”</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 9 дүгээр зүйлийн</p> <p>9.1.3. агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох;</p>	<p>Энэхүү хуулийн заалтаар аж ахуйн нэгж байгууллагад үүрэг ногдуулсан хэдий ч үүргээ хэрэгжүүлээгүй бол ямар хариуцлага ногдуулах тухай зохицуулалт байхгүй байгаа нь хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлөх юм.</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 31 дүгээр зүйлийн 31.1.4.-д “агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл агаарт гаргах бохирдуулах бодис, физикийн сөрөг</p>

			<p>нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглоогүй, багаж хэрэгсэлийг ашиглах журам зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох; эсхүл үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээ авна” гэж оруулах.</p>
<p>Агаарын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.</p> <p>“Шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага нь дангаараа, эсхүл холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран агаарын бохирдлыг бууруулах, хянах чиглэлээр бусад стандартыг боловсруулж батлуулна.”</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 14 дүгээр зүйлийн 14.3.</p> <p>Шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага нь дангаараа, эсхүл холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран агаарын бохирдлыг бууруулах, хянах чиглэлээр бусад стандартыг боловсруулж батлуулна.</p>	<p>Энэхүү зүйл заалтад “Шаардлагатай тохиолдолд” гэдэг нь хэт ерөнхий зохицуулалт болсон байна. Төрийн захиргааны төв байгууллага онцгой нөхцөл байдал үүссэн хэдий “Шаардлагатай тохиолдол” гэж үзэхгүй бол стандарт боловсруулахгүй байх боломжтой бөгөөд ингэсэн тохиолдолд ямар нэгэн хариуцлага тооцох боломжгүй болж байгаа юм.</p>	<p>“Төрийн захиргааны төв байгууллага зайлшгүй батлах шаардлагатай стандартын жагсаалтыг судалгааны үндсэн дээр жил бүрийн эхний улиралд гаргах бөгөөд жагсаалтад багтсан стандартуудыг тухайн жилд багтаан холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.</p>
<p>Агаарын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4.</p> <p>“Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байвал зохино.”</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 15 дугаар зүйлийн 15.5. “Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байвал зохино.”</p>	<p>Энэ эзэнгүй заалт мэт харагдаж байна. Хэн бохирдуулах бодисын агууламжийг агаарын чанарын стандартын хэмжээнд байлгах нь тодорхойгүй, хэнд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй.</p>	<p>Хуулийн төслийн 8 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд “Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас</p>

			хэтрэхгүй байлгахад шаардлагатай арга хэмжээ авах.
<p>Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.</p> <p>“Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т<sup>6</sup> заасан бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан байхад тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтанд “Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтооно.”</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 16 дугаар зүйлийн 16.3. Энэ хуулийн 16.2-т заасан бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p>7 дугаар зүйлийн 7.1.9. агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, цуцлах, хүчингүй болгох, суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг.</p>	<p>Өөрөөр хэлбэл Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт хаягдлын хэмжээг хэрхэн, ямар аргачлалаар, яаж тогтоох арга механизмыг журамлах зохицуулалт гэж ойлгогдохоор хуульчилсан байхад мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтанд “Хаягдлын хэмжээг тогтооно” гэж заасан нь зөрчилдсөн байна. “Хэмжээг тогтоох”, “Хэмжээ тогтоох журмыг тогтоох” гэдэг нь ялгаатай ойлголт юм.</p>	<p>Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.9. “Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтооно” гэснийг “Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг тогтооно” гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Эсхүл зөвшөөрөгдөх хаягдлыг, мөн зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журам хоёуланг Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоох бол үүний ялгааг тодруулан хуульчлах нь зүйтэй.</p>
<p>Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.</p> <p>“Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандарт, физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоох буюу үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх саналыг байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад тавих бөгөөд уг саналыг эрх бүхий байгууллага 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ”</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 18 дугаар зүйлийн 18.4.</p> <p>Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандарт, физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоох буюу үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх саналыг байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад тавих бөгөөд уг саналыг эрх бүхий байгууллага 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.</p>	<p>Уг заалтын утга нь зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамааралтай зохицуулалт болсон байна. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд “Тусгай зөвшөөрлийг зогсоох” гэсэн ойлголт байхгүй бөгөөд хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн тохиолдолд “Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлнэ”, харин удаа дараа зөрчсөн бол “Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгодог”. Мөн “Үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх” гэсэн хуулийн зохицуулалт тус хуульд байхгүй. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай</p>	<p>Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандарт, физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад тавих бөгөөд уг саналыг эрх бүхий байгууллага 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.</p>

		<p>зөвшөөрлийн тухай хуульд бусад тусгай зөвшөөрөл олгох асуудлыг зохицуулж байгаа бусад хууль нийцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл: Агаарын тухай хуульд “Тусгай зөвшөөрлийг зогсоох, үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх” гэж заасан нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуультай зөрчилдсөн байна.</p>	
<p>Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.</p> <p>“Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартыг үндэслэнэ.”</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 19 дугаар зүйлийн 19.1.</p> <p>“Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартыг үндэслэнэ.”</p>	<p>Энэхүү зохицуулалт ямар нэг хууль зүйн үр дагавар үүсгэхгүй байна. Хэрэв дээр дурдсан стандартад үндэслээгүй барилга байгууламжийн байршлыг сонгосон, зураг төсөл зохиосон, барьсан гэх мэт хуульд заасан үйлдлүүд хийсэн бол ямар хууль зүйн үр дагавар үүсэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл: Уг барилга байгууламжийг барих ажлыг зогсоох гэх мэт уг хуулийн хэрэгжилтийг хангах дараагийн арга хэмжээ хуульд тусгагдсан байх шаардлагатай. Иймд уг зохицуулалтыг цаашид хэрэгжих механизмыг тодорхой болгох шаардлагатай байна. Тус хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтанд “...агаарыг хамгаалах шаардлага хангаагүй барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, техник, технологи нэвтрүүлсэн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг дөрвөөс тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг наймаас ес дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох”-оор</p>	<p>Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартыг үндэслэх бөгөөд стандартын дагуу хийгдээгүй зураг төсөлд барилгын ажил эрхлэх зөвшөөрөл олгохгүй, мөн барилгын ажил эхэлсэн тохиолдолд барилгын ажлыг зогсоох хүртэлх арга хэмжээ авахаар хуульчлах нь зүйтэй.</p>

		санкц ногдуулсан нь хууль зөрчсөн тохиолдолд зөвхөн 700000-1300000 төгрөгөөр торгохоор байгаа нь уг хориглосон зохицуулалт ач холбогдолгүй болж байна. Нэгэнт уг стандартын дагуу зураг төслөө хийгээгүй, барилга байгууламж барьсаны дараа хариуцлага тооцох заалт байгаа юм.	
<p>Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.</p> <p><i>“Агаарт онцгой хортойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих асуудлыг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.”</i></p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 19 дүгээр зүйлийн 19.3.</p> <p><i>“Агаарт онцгой хортойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих асуудлыг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.”</i></p>	<p><i>“Агаарт онцгой хортойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламж”</i> гэдэгт нь ямар үйлдвэрлэл үйлчилгээний барилга байгууламж хамаарах нь тодорхойгүй байгаа энэхүү заалт хэрэгжихэд хүндрэлтэй юм.</p>	<p>Хуулийн нэр томъёоны хэсэгт <i>“Агаарт онцгой хортойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламж”</i> гэснийг хэрхэн ойлгох талаар тайлбар хийх нь зүйтэй байна. Эсхүл шалгуурыг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна.</p>
<p>Агаарын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.</p> <p><i>“Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.”</i></p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 23 дүгээр зүйлийн 23.1. <i>“Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.</i></p>	<p>Тусгай зөвшөөрөл олгох харилцааг зөвхөн Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн болон бусад хуулиар зохицуулдаг. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөлийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1. <i>“Энэ хуулийн зорилт нь нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй, тодорхой нөхцөл, нарийн мэрэгжил шаардах аж ахуйн зарим үйл ажиллагааг эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино”</i> гэж заасан байх бөгөөд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг уг хуулиар</p>	<p>Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны нэр томъёог адилтгаж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна.</p>

		<p>зохицуулах эрх зүйн үндэслэл бий болж байгаа юм. Гэтэл “Тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална” гэж заасан нь хууль зөрчсөн байна.</p> <p>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.1. “Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах” зөвшөөрөл гэж заасан бөгөөд энэ нь тус хуулиар зохицуулагдаж байна.</p>	
<b>Засгийн газрын бүрэн эрхтэй холбоотой асуудлаар:</b>			
<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 6 дугаар зүйлийн 6.2. “Засгийн газар нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гээд энэхүү зүйлд заагдсан заалтуудыг зөвхөн нийслэлд хамааруулахаар заасан байна.</p> <p>Агаарын тухай Монгол улсын хуульд зөвхөн нийслэлтэй хамааралтай зохицуулалт орж байгаа нь тохиромжгүй байх бөгөөд Засгийн газар энэхүү бүрэн эрхээ бусад аймаг, сумдад хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.</p>	<p>Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-д зүйлд заагдсан зүйлүүдийн ард “аймаг нийслэлийн” гэж оруулах</p> <p>Хуулийн төслийн 6.2.8-г 6.2.4 болгон “Үндэсний хорооны саналыг үндэслэн нийслэл, бусад суурин газрын агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах улсын болон тухайн бүс нутгийн төсөвт тусгагдсанаас бусад хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газрын бонд гаргах хэлбэрээр шийдвэрлэх” гэж найруулах.</p>		
<b>Төсөлд оруулах нэмэлт санал:</b>			
<b>Тайлбар</b>	<b>Нэмэлт санал</b>		
<p>Хуульд уг хорооны бүрэн эрхийг тодорхой тусгаагүй, Байгаль орчны асуудал эрхсэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй давхардсан шинжтэй, мөн уг хорооны шийдвэрийг хэн хэрэгжүүлэх, хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлоогүй.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хуулийн төслийн 5.1.2-г “Улсын Их Хурал, засгийн газраас баталсан агаарыг хамгаалах төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, уялдааг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороог (цаашид “Үндэсний хороо” гэх) байгуулах” гэж найруулах,</li> <li>2. Хуулийн төслийн 5.2-г “Энэ хуулийн 5.1.2-д заасан Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхийлөгч батална” гэж найруулах,</li> <li>3. Хуулын төслийн 5.3 –д “Үндэсний хороо нь Агаарын бохирдлыг бууруулах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: <ol style="list-style-type: none"> <li>5.3.1 Үндэсний хороо нь Засгийн газраас баталсан агаарыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд агаарын бохирдлын бууруулах жил бүрийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах.</li> <li>5.3.2 Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг Засгийн газарт мэдүүлж батлуулах. санхүүжилтэд хяналт тавих;</li> <li>5.3.3 Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар холбогдох</li> </ol> </li> </ol>		



	<p>байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;</p> <p>5.3.4 Агаарын бохирдлыг бууруулах талаар хийж байгаа ажил, ажлын төлөвлөгөөний биелэлтийн тухай холбогдох албан тушаалтны сонсгол тайланг авч хэлэлцэх, мэдээ тайлан гаргуулах;</p> <p>5.3.5 Агаар бохирдуулах бодисын агууламж, физикийн сөрөг нөлөөллийн түвшин стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн түүнчлэн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасны дагуу зарим ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг шууд гэрээ байгуулах замаар худалдан авах зөвшөөрлийг хорооны хурлаар шийдвэрлэн холбогдох байгууллагад олгох;</p> <p>5.3.6 Агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих, ажлын чиглэл зааварчилгаа өгөх, шаардлагатай арга хэмжээг авах;</p> <p>5.3.7 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа дотоод, гадаадын төсөл, хөтөлбөр, сангийн үйл ажиллагааны нэгдсэн мэдээлэл судалгааны санг бүрдүүлж харилцан уялдааг хангаж зохицуулах;</p> <p>5.3.8 Агаарын чанарын мэргэжлийн албадын үйл ажиллагааг удирдан чиглүүлж нэгдсэн удирдлагаар хангах, шаардлагатай судалгаа, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргуулан авах;</p> <p>5.3.9 Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвх санаачилгыг дэмжиж урамшуулах, агаарын төлөв байдлын тухай нийтэд мэдээлдэг тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах;</p> <p>5.3.10 Нийслэлийн болон бусад хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний талаар саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>5.3.11 Агаарын бохирдлыг бууруулах тухай хууль тогтоомжид заасан бүрэн эрх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэл боловсруулах, санал гаргах, үндэслэл саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг гаргуулах,</p> <p>5.3.12 Үндэсний хороо нь өмнөх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөны биелэлтийг хэлэлцэж, үр дүнг нь олон нийтэд ил тод нийтэд мэдээлэх.</p> <p>5.3.13 Үндэсний хороо нь аймаг, нийслэлд өөрийн салбар хороог байгуулж болно.</p> <p>4. Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.6. “агаарын бохирдлыг бууруулах талаар хууль тогтоомжид заасан бүрэн эрх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн эсхүл үндэсний хорооноос албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр үндэслэл боловсруулж, санал гаргасан бол тухайн шатны албан тушаалтанд төрийн албаны тухай хуульд заасан арга хэмжээ авна” гэж өөрчлөх.</p>
<p><b>Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй холбоотой асуудлаар:</b></p>	

<p>Харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтад “Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглахдаа сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна” гэж заасан байна. Агаарын тухай хуулиар “Томоохон суурин эх үүсвэр” ашиглахад тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу агаарт бохирдуулах бодис гаргаж, физикийн хортой нөлөөлөл үзүүлж байгаа бол ямар ч ялгамжгүйгээр бүгд тусгай зөвшөөрөл авахаар заасан нь илүү өргөн хүрээг хамарч байх тул эдгээр заалтууд зөрчилдөх үндэслэл болж байна.</p>	<p>Мөн “энэ хуулийн 7.1.11-д зааснаас бусад зөвшөөрөл олгох” гэж нэмэх,</p>
<p><b>Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхтэй холбоотой асуудлаар:</b></p>	
<p>Нутгийн өөрөө удирдах байгууллага болох Үндэсний хорооны хоорондын уялдаа холбоог тодорхой болгох шаардлагатай.</p>	<p>Хуулийн төслийн Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн жилд агаарын бохирдлыг бууруулахад авах арга хэмжээний төлөвлөгөө, болон агаарын бохирдлыг бууруулахад тухайн бүс нутагт гүйцэтгэгдсэн үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн талаарх тайланг Үндэсний хороонд хүргүүлэх, хэрэгжилтийг хангах</p>
<p><b>Цэвэр агаар сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар:</b></p>	
<p>Цэвэр агаарын сангийн эрх зүйн зохицуулалтад удирдах зөвлөлийн үндсэн эрх хэмжээг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Журмаар бол зөвхөн ажиллах үйл ажиллагааг журамлах бөгөөд эрх хэмжээг нь хуулиар тодорхойлох шаардлагатай.</p>	<p>Хуулийн төсөлд Цэвэр агаарын сангийн дүрэм болон тус сантай холбоотой дүрэм журам, бүтэц, тухайн жилийн төсөв, тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөө, урт болон дунд шатны үйл ажиллагааны хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг хэлэлцэж хэлэлцэж батлах, Төсвийн ерөнхийлөн захирагч нь удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах.</p>
<p><b>Холбогдох болон дагалдах бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар:</b></p>	
<p>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтад “Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглахдаа сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна” гэж заасан байна. Агаарын тухай хуулийн төслийн 7.1.9. “агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, цуцлах, хүчингүй болгох, суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг, түүнчлэн агаарын чанарын мэргэжлийн албаны дүгнэлт гаргуулах ажиллагааны үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээг тогтоох;” бүрэн эрхийн Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд хамааруулан заасан байна. Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд “<b>томоохон эх үүсвэр</b>” гэсэн заалт байхгүй мөн томоохон эх үүсвэрт тусгай зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны байгууллагын олгох тусгай зөвшөөрлийн төрөлд байхгүй байгаа юм. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу агаарт бохирдуулах бодис гаргаж, физикийн хортой нөлөөлөл үзүүлж байгаа бол ямар ч ялгамжгүйгээр бүгд тусгай зөвшөөрөл авахаар заасан нь илүү өргөн хүрээг хамарч байх тул эдгээр заалтууд зөрчилдөх үндэслэл болж байна.</p>	<p>Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.8-д заасан “агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр”-н “<b>зөвшөөрөл олгох</b>” гэдгийг нэж оруулах</p> <p><i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-дахь заалтыг 34.1.5. “гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй болсон, эсхүл Агаарын тухай хуулийн 5.3.5-д заасан нөхцөл байдал бий болсон бол) гэж өөрчлөлт оруулах.</i></p>

## 8.9. Хавсралт 9. Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулгад өгөх санал.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ			
Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/	Төслийн багын санал	Яамны санал	Эцсийн санал
<b>Агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахтай холбоотой үндсэн зохицуулалтын талаар:</b>			
Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 7 дугаар зүйлийн 7.1.8.  <b><u>“озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах, хязгаар тогтооход хяналт тавих.”</u></b>	“Төрийн захиргааны байгууллага озон задалдаг бодисын хэрэглээг үе шаттайгаар бууруулах хөтөлбөр боловсруулах уг хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих” гэж оруулах.	1999 оны 104 тоот журмаар уг харицлааг зохицуулж байгаа бөгөөд журамд озон задалдаг бодисын дээд хязгаарыг жил бүр 1 дүгээр сард багтаан Байгаль орчны яам тогтоохоор журамласан байна. Олон улсын гэрээний дагуу хүлээх үүргийн дагуу энэ журам батлагдсан.	Хуулинд өөрчлөлт оруулах шаардлагагүй
Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 9 дүгээр зүйлийн  9.1.3. агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхдээ тухайн эх үүсвэрийн хаягдал, нөлөөллийг хянах дотоод хяналтын багаж хэрэгслээр тоноглох;	Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 31 дүгээр зүйлийн 31.1.4.-д “агаарт бохирдуулах бодис гаргах, физикийн сөрөг нөлөөлөл үзүүлэх талаар зөвшөөрөлд заасан хэмжээ, нөхцөл, шаардлагыг зөрчсөн, эсхүл агаарт гаргах бохирдуулах бодис, физикийн сөрөг нөлөөллийг багасгах, цэвэрлэх, хянах тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр тоноглоогүй, багаж хэрэгслийг ашиглах журам зөрчсөн иргэнийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурваас тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох; эсхүл үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэлх хугацаанд зогсоох арга хэмжээ авна” гэж оруулах.	Төслийн багын саналд өөрчлөлт ороогүй	Төслийн багын саналд өөрчлөлт ороогүй
”Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 14 дүгээр зүйлийн 14.3.	“Төрийн захиргааны төв байгууллага зайлшгүй батлах шаардлагатай стандартын жагсаалтыг судалгааны үндсэн дээр жил бүрийн эхний улиралд	<i>Жил бүр стандартын жагсаалт гаргах шаардлага байхгүй, одоо дагаж мөрдөж байгаа стандарт,</i>	Мэргэжлийн хяналтын газар болон стандарт хэмжил зүйн газраас стандартын

<p>Шаардлагатай тохиолдолд төрийн захиргааны төв байгууллага нь дангаараа, эсхүл холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран агаарын бохирдлыг бууруулах, хянах чиглэлээр бусад стандартыг боловсруулж батлуулна.</p>	<p>гаргах бөгөөд жагсаалтад багтсан стандартуудыг тухайн жилд багтаан холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батална.</p>	<p><i>хэрэгжихэд хүндрэлтэй болсон, эсхүл нэмж стандарт гаргах шаардлагатай тохиолдолд стандарт гаргах</i></p>	<p>хэрэгжилтийн талаарх тайлан мэдээг жил бүр байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Төрийн захиргааны төв байгууллага тайлан мэдээнд үндэслэн шаардлагатай гэж үзвэл дангаараа, эсхүл холбогдох төрийн захиргааны байгууллагатай хамтран агаарын бохирдлыг бууруулах, хянах чиглэлээр бусад стандартыг боловсруулж батлуулна. Гэж өөрчилөх,</p>
<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 15 дугаар зүйлийн 15.5. “Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байвал зохино”</p>	<p>Хуулийн төслийн 8 дугаар зүйл. Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд “Агаарын чанарыг сайжруулах бүсэд хамаарах газар нутгийн хэмжээнд аливаа бохирдуулах бодисын хамгийн их агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхгүй байлгахад шаардлагатай арга хэмжээ авах</p>	<p>Саналд өөрчлөлт ороогүй</p>	<p>Саналд өөрчлөлт ороогүй</p>
<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 16 дугаар зүйлийн 16.3. Энэ хуулийн 16.2-т заасан бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг төрийн захиргааны төв байгууллага батална. 7 дугаар зүйлийн 7.1.9. агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, цуцлах, хүчингүй болгох, суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг.</p>	<p>Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.9. “Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтооно” гэснийг “Суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журмыг тогтооно” гэж өөрчлөх нь зүйтэй гэж үзэж байна. Эсхүл зөвшөөрөгдөх хаягдлыг, мөн зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг тогтоох журам хоёуланг Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоох бол үүний ялгааг тодруулан хуульчлах нь зүйтэй.</p>	<p>“Хэмжээ тогтоох журмыг” биш шууд “Хэмжээ”-г тогтоож байгаа. Иймээс хэмжээ тогтоох гэж нэр мөр болгох</p>	<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 16 дугаар зүйлийн 16.3. Энэ хуулийн 16.2-т заасан бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг төрийн захиргааны төв байгууллага тогтооно гэж өөрчилөх.</p>
<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 18 дугаар зүйлийн 18.4.</p>	<p>Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандарт, физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, зөвшөөрөлд заасан нөхцөл,</p>	<p>Саналд өөрчлөлт ороогүй</p>	<p>Саналд өөрчлөлт ороогүй</p>

<p>Агаар бохирдуулах бодисын хаягдлын стандарт, физикийн сөрөг нөлөөллийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, зөвшөөрөлд заасан нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоох буюу үйлдвэрлэлийн чиглэлийг нь өөрчлөх саналыг байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад тавих бөгөөд уг саналыг эрх бүхий байгууллага 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.</p>	<p>шаардлагыг удаа дараа зөрчсөн аж ахуйн нэгж, байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох саналыг байгаль орчны болон эрүүл ахуйн улсын байцаагч зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагад тавих бөгөөд уг саналыг эрх бүхий байгууллага 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.</p>		
<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 19 дугаар зүйлийн 19.1. “Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартыг үндэслэнэ”</p>	<p>Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартыг үндэслэх бөгөөд стандартын дагуу хийгдээгүй зураг төсөлд барилгын ажил эрхлэх зөвшөөрөл олгохгүй, мөн барилгын ажил эхэлсэн тохиолдолд барилгын ажлыг зогсоох хүртэлх арга хэмжээ авахаар хуульчлах нь зүйтэй.</p>	<p>Барилгын тухай хуульд мөн заалт оруулах</p>	<p>Барилгын тухай хуульд “Үйлдвэрлэл, үйлчилгээний болон бусад зориулалттай барилга байгууламжийн байршлыг сонгох, зураг төсөл зохиох, барих, өргөтгөл, шинэчлэл, засварын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах, технологи, тоног төхөөрөмж суурилуулах, тэдгээрийг өөрчлөх, шинэчлэхэд агаарын чанарын стандарт болон физикийн сөрөг нөлөөллийн стандартад нийцэж байгаа эсэх талаарх саналыг байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагаас авах” талаарх зохицуулалтыг оруулах</p>

<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 19 дүгээр зүйлийн 19.3. “Агаарт онцгой хортойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих асуудлыг зохих шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүгнэлтийг үндэслэн барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ”</p>	<p>Хуулийн нэр томъёоны хэсэгт “Агаарт онцгой хортойгоор нөлөөлж болзошгүй үйлдвэрлэл үйлчилгээний зориулалт бүхий барилга байгууламж” гэснийг хэрхэн ойлгох талаар тайлбар хийх нь зүйтэй байна. Эсхүл шалгуурыг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна.</p>	<p>Саналд өөрчлөлт ороогүй</p>	<p>Саналд өөрчлөлт ороогүй</p>
<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 23 дүгээр зүйлийн 23.1. “Озон задалдаг бодис, түүнийг агуулсан тоног төхөөрөмжийн жагсаалт болон тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална.</p>	<p>Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны нэр томъёог адилтгаж Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна.</p>	<p>“Озон задалдаг бодис, түүнийг агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, худалдах, ашиглах” зөвшөөрөл нь тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгоход хүндрэл учирна.</p>	<p>Тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулж</p>
<p><b>Засгийн газрын бүрэн эрхтэй холбоотой асуудлаар:</b></p>			
<p>Агаарын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2011 оны төсөл/-ийн 6 дугаар зүйлийн 6.2. “Засгийн газар нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гээд энэхүү зүйлд заагдсан заалтуудыг зөвхөн нийслэлд хамааруулахаар заасан байна.</p> <p>Агаарын тухай Монгол улсын хуульд зөвхөн нийслэлтэй хамааралтай зохицуулалт орж байгаа нь тохиромжгүй байх бөгөөд Засгийн газар энэхүү бүрэн эрхээ бусад аймаг, сумдад хэрэгжүүлэх боломжгүй болгож байна.</p>	<p>Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-д зүйлд заагдсан зүйлүүдийн ард “аймаг нийслэлийн” гэж оруулах</p> <p>Хуулийн төслийн 6.2.8-г 6.2.4 болгон “Үндэсний хорооны саналыг үндэслэн нийслэл, бусад суурин газрын агаарыг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулахад шаардагдах улсын болон тухайн бүс нутгийн төсөвт тусгагдсанаас бусад хөрөнгийн эх үүсвэрийг Засгийн газрын бонд гаргах хэлбэрээр шийдвэрлэх” гэж найруулах;</p>		
<p>Агаарын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д зааснаар Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслээс ялгарах нүүрс хүчлийн хийн төлбөрийг тэдгээрийн ангиллаас хамаарсан хувь, хэмжээгээр дараахь байдлаар тогтооно гээд автомашин өөрөө явагч хэрэгслийн нүүрс хүчлийн хийн ялгарлыг г/км гэсэн нэгжээр тооцож авч байна. Энэхүү нэг км зам туулахад хэдэн грам нүүрс хүчлийн хий ялгаруулж байгааг хэмжих багаж одоогоор Монгол улсад байхгүй байх бөгөөд уг багаж нь нэг ширхэг нь бараг нэг тэр бум төгрөгийн үнэтэй тул зөвхөн уг багаж авахад 30-аад тэрбум төгрөг шаардлагатай болоод байгаа талаар санал солилцсон.</p>	<p>Энэхүү төлбөр тооцох нэгжийг өөрчилөх шаардлагын дагуу ярилцаж шатахууны литр тутам 1-3 төгрөгийн татвар төлөхөөр энэ хязгаарыг хуульчилж өгөх хэрэгтэй бөгөөд энэ хязгаар дотор Засгийн газар төлбөрийн хэмжээг тогтоохоор хуульчлах санал өгч байна. Энэ нь хэрэглэгчид төдийлөн дарамт болохгүй бөгөөд одоо төлж байгаа төлбөр нь төдийлөн нэмэгдэхгүй юм. Монгол улсад барагцаагаар 1 сая тонн шатахуун орж ирж байгаа тооцоо байна. Энэ тооцоогоор бодоход жилд 10 тэрбум төгрөг уг татвараас орж ирэх боломжтой.</p>		
<p>Харин Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтад “Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр</p>	<p>Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэх</p>		

<p>ашиглахдаа сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна” гэж заасан байна. Агаарын тухай хуулиар “Томоохон суурин эх үүсвэр” ашиглахад тусгай зөвшөөрөл авах шаардлагатай бол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу агаарт бохирдуулах бодис гаргаж, физикийн хортой нөлөөлөл үзүүлж байгаа бол ямар ч ялгамжгүйгээр бүгд тусгай зөвшөөрөл авахаар заасан нь илүү өргөн хүрээг хамарч байх тул эдгээр заалтууд зөрчилдөх үндэслэл болж байна.</p>	
<p><b>АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ САНАЛ ТУСГАСАН БАЙДАЛ. Төсөлд нэмэлтээр оруулах санал:</b></p>	
<p>Тайлбар:</p>	<p>Нэмэлт оруулах санал:</p>
<p>Хуульд уг хорооны бүрэн эрхийг тодорхой тусгаагүй, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхтэй давхардсан шинжтэй, мөн уг хорооны шийдвэрийг хэн хэрэгжүүлэх, хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлоогүй.</p>	<p>5. Хуулийн төслийн 5.1.2-г “Улсын Их Хурал, засгийн газраас баталсан агаарыг хамгаалах төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, уялдааг зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий Үндэсний хороог (цаашид “Үндэсний хороо” гэх) байгуулах” гэж найруулах,</p> <p>6. Хуулийн төслийн 5.2-г “Энэ хуулийн 5.1.2-д заасан Үндэсний хорооны бүтэц, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхийлөгч батална” гэж найруулах,</p> <p>7. Хуулын төслийн 5.3 –д “Үндэсний хороо нь Агаарын бохирдлыг бууруулах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.3.14 Үндэсний хороо нь Засгийн газраас баталсан агаарыг хамгаалах үндэсний хөтөлбөрийн хүрээнд агаарын бохирдлын бууруулах жил бүрийн үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулах.</p> <p>5.3.15 Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг Засгийн газарт мэдүүлж батлуулах санхүүжилтэд хяналт тавих;</p> <p>5.3.16 Агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэх асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих;</p> <p>5.3.17 Агаарын бохирдлыг бууруулах талаар хийж байгаа ажил, ажлын төлөвлөгөөний биелэлтийн тухай холбогдох албан тушаалтны сонсгол тайланг авч хэлэлцэх, мэдээ тайлан гаргуулах;</p> <p>5.3.18 Агаар бохирдуулах бодисын агууламж, физикийн сөрөг нөлөөллийн түвшин стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн түүнчлэн хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-д заасны дагуу зарим ажил үйлчилгээ, бараа бүтээгдэхүүнийг шууд гэрээ байгуулах замаар худалдан авах зөвшөөрлийг хорооны хурлаар шийдвэрлэн холбогдох байгууллагад олгох;</p> <p>5.3.19 Агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих, ажлын чиглэл зааварчилгаа өгөх, шаардлагатай арга хэмжээг авах;</p> <p>5.3.20 Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ажиллаж байгаа дотоод, гадаадын төсөл, хөтөлбөр, сангийн үйл</p>

	<p>ажиллагааны нэгдсэн мэдээлэл судалгааны санг бүрдүүлж харилцан уялдааг хангаж зохицуулах;</p> <p>5.3.21 Агаарын чанарын мэргэжлийн албадын үйл ажиллагааг удирдан чиглүүлж нэгдсэн удирдлагаар хангах, шаардлагатай судалгаа, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргуулан авах;</p> <p>5.3.22 Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, идэвхи санаачилгыг дэмжиж урамшуулах, агаарын төлөв байдлын тухай нийтэд мэдээлдэг тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах;</p> <p>5.3.23 Нийслэлийн болон бусад хот, суурин газрын агаарын бохирдлыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний талаар саналаа Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>5.3.24 Агаарын бохирдлыг бууруулах тухай хууль тогтоомжид заасан бүрэн эрх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэл боловсруулах, санал гаргах, үндэслэл саналыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг гаргуулах,</p> <p>5.3.25 Үндэсний хороо нь өмнөх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөны биелэлтийг хэлэлцэж, үр дүнг нь олон нийтэд ил тод мэдээлэх.</p> <p>5.3.26 Үндэсний хороо нь аймаг, нийслэлд өөрийн салбар хороог байгуулж болно.</p> <p>8. Хуулийн төслийн 31 дүгээр зүйлийн 31.1.6. “агаарын бохирдлыг бууруулах талаар хууль тогтоомжид заасан бүрэн эрх, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хангалтгүй биелүүлсэн эсхүл үндэсний хорооноос албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхээр үндэслэл боловсруулж, санал гаргасан бол тухайн шатны албан тушаалтанд төрийн албаны тухай хуульд заасан арга хэмжээ авна” гэж өөрчлөх.</p>
<p><b>Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхтэй холбоотой асуудлаар:</b></p>	
<p>Нутгийн өөрөө удирдах байгууллага болох Үндэсний хорооны хоорондын уялдаа холбоог тодорхой болгох шаардлагатай.</p>	<p>Хуулийн төслийн Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхэд “Нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн жилд агаарын бохирдлыг бууруулахад авах арга хэмжээний төлөвлөгөө, болон агаарын бохирдлыг бууруулахад тухайн бүс нутагт гүйцэтгэгдсэн үйл ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийн талаарх тайланг Үндэсний хороонд хүргүүлэх, хэрэгжилтийг хангах</p>
<p><b>Холбогдох болон дагалдах бусад хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар:</b></p>	
<p>Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1 дэх заалтад “Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх, суурин эх үүсвэр ашиглахдаа сум, дүүргийн Засаг даргаас зөвшөөрөл авна” гэж заасан байна. Агаарын тухай хуулийн төслийн 7.1.9.”агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг ашиглах зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, цуцлах, хүчингүй болгох, суурин эх үүсвэрээс агаарт гаргах зөвшөөрөгдөх хаягдлын хэмжээг, түүнчлэн агаарын чанарын мэргэжлийн албаны дүгнэлт гаргуулах ажиллагааны үйлчилгээний хөлс, хураамжийн хэмжээг тогтоох” бүрэн эрхийн Байгаль орчны асуудал эрхлэсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд хамааруулан заасан байна. Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуульд “томоохон эх үүсвэр” гэсэн заалт байхгүй мөн томоохон эх үүсвэрт тусгай</p>	<p>Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15.6.8-д заасан “агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэр”-н “зөвшөөрөл олгох” гэдгийг нэмж оруулах</p>



<p>зөвшөөрлийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын олгох тусгай зөвшөөрлийн төрөлд байхгүй байгаа юм. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн дагуу агаарт бохирдуулах бодис гаргаж, физикийн хортой нөлөөлөл үзүүлж байгаа бол ямар ч ялгамжгүйгээр бүгд тусгай зөвшөөрөл авахаар заасан нь илүү өргөн хүрээг хамарч байх тул эдгээр заалтууд зөрчилдөх үндэслэл болж байна</p>	
<p>Агаарын бохирдлын хэмжээ ихсэж хүн амын эрүүл мэндэд хохирол учруулах хэмжээнд хүрсэн тохиолдолд тендер зарлахад хугацаа алдаж байгаа юм.</p>	<p><i>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5-дахь заалтыг 34.1.5. "гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас нээлттэй буюу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмын дагуу тендер хүлээн авах доод хугацааг мөрдөх боломжгүй болсон, эсхүл Агаарын тухай хуулийн 5.3.5-д заасан нөхцөл байдал бий болсон бол) гэж өөрчлөлт оруулах.</i></p>

<b>ЦЭВЭР АГААРЫН САНГИЙН ӨГСӨН САНАЛЫГ ТУСГАСАН БАЙДАЛ</b>	
<b>Цэвэр агаарын сангийн зүгээс өгсөн санал</b>	<b>Эцсийн санал</b>
Цэвэр агаарын сангийн эрх зүйн зохицуулалтад удирдах зөвлөлийн үндсэн эрх хэмжээг хуульчилж өгөх шаардлагатай гэж үзэж байна. Журмаар бол зөвхөн ажиллах үйл ажиллагааг журамлах бөгөөд эрх хэмжээг нь хуулиар тодорхойлох шаардлагатай.	Хуулийн төсөлд “Цэвэр агаарын сангийн дүрэм, болон тус сантай холбоотой дүрэм журам, бүтэц, тухайн жилийн төсөв, тайлан, үйл ажиллагааны төлөвлөгөө, урт болон дунд шатны үйл ажиллагааны хөтөлбөр, стратеги төлөвлөгөөг хэлэлцэж батлах, Төсвийн ерөнхийлөн захирагч нь удирдах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн хөрөнгийг захиран зарцуулах, тайлагнах эрх бүхий Цэвэр агаарын сангийн үйл ажиллагааг зохицуулах олон талын оролцоог хангах орон тооны бус Удирдах зөвлөлтэй байна.” гэж өөрчилөх
Аж ахуйн нэгж байгууллагад “Цэвэр агаарын сан”-гаас татаас олгож байгаа. Энэхүү татаас олгож байгаа харилцааны эрх зүйн зохицуулалт нарийвчлан зохицуулагдаагүй байгаагаас хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулж байгаа Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 121.2.2. “стандартын шаардлагад нийцсэн цэвэр түлш, зуух үйлдвэрлэхийг дэмжих, тэдгээрийг худалдан авахад татаас олгох”; гэж заасан боловч энэ нь хэрэгжихэд зохицуулалтын хувьд тодорхойгүй асуудлууд гарч байна.	Засгийн газрын тусгай сангийн тухай хууль 121.2.2. “стандартын шаардлагад нийцсэн цэвэр түлш, зуух үйлдвэрлэхийг дэмжих, тэдгээрийг худалдан авахад <b>худалдан авагчид тусламж үзүүлэх зорилгоор</b> татаас олгох;” Ийнхүү тусламжийн зориулалтаар татаас олгоход бараа үйлчилгээ худалдан авах гэсэн ойлголтод хамаарахгүй гэж үзэж байна.
Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн А-200 тоот тушаалаар батлагдсан “ <b>Цэвэр агаарын санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам</b> ”-ын 4.1 дүгээр заалт бусад орлого гэсэн нь хуулиар орлого зөвшөөрөгдсөн тохиолдолд хэрэглэгдэх заалт. Иймээс “ <b>хуульд заасан бусад орлого</b> ” болгох	<b>“хуульд заасан бусад орлого” гэж оруулах</b>
Үндэсний хорооны бүрэн эрхийг хуульчлах	Үндэсний хорооны бүрэн эрхийг хуульчилж оруулсан болно.